

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР




**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

## **1.1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Засгийн газрын 2017 оны 344 дүгээр “Агентлаг байгуулах тухай” тогтоол, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 04 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/25 дугаар “Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай” тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар “Бүтэц, орон тоо батлах тухай” тушаалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг үүргийг 6 газар, 5 хэлтэс, дэргэдээ 2 төвтэй байхаар шинэчлэн баталсны дагуу 2022 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Тамгын газар, Дотоод аудит, мониторингийн газар, Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар болон Хуулийн хэлтэс, Үйл ажиллагааны хөгжлийн хэлтэс, Судалгааны хэлтэс, Хуримтлалын сан, өрийн удирдлагын хэлтэс, Олон нийттэй харилцах хэлтэс гэсэн нэгжүүдэд нийт 82 ажилтан, албан хаагчтай, дэргэдэх Мэдээллийн технологийн төв 13, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс 8, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төвийн нийгмийн даатгалын тасаг 8 албан хаагчидтай ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/23 дугаар “Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан үндсэн чиг үүргийн дагуу нийгмийн даатгалын байгууллагын эрхэм зорилго, стратеги зорилгуудыг хангахуйц хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, бодлого, үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байдлыг хангах замаар байгууллагын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагч, тэтгэвэр авагчдад чирэгдэлгүй шуурхай хүргэх боломжийг судлах, орчин үеийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, нийгмийн даатгалын төрөөс хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангуулах, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэхтэй холбоотой тооцоо, судалгаа хийх, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах, нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, зардлын санхүүжилтийг хуулийн хугацаанд олгох, төсвийн гүйцэтгэлийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулж сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын хамралт, сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хуримтлагдсан өр авлагын барагдуулалт, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлын тогтоолтод хяналт тавих, аливаа хууль бус үйлдэл гарахаас урддчилан сэргийлж, зөрчлийг арилгуулах, Монгол улсын Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, газрын болон хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, нийгмийн даатгалын салбарын ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт зохион байгуулах, нийгмийн даатгалын хууль тогтоомж болон тэдгээрийн шинэчлэлийн талаарх мэдээллийг даатгуулагч, ажил олгогчид таниулан сурталчилах зэрэг ажлуудыг Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 67 арга хэмжээний хүрээнд тусган хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Мөн орон нутагт нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын 31 /газар/ хэлтсүүдэд 1,416 ажилтан, албан хаагчид ажиллаж байна.



### 1.1.1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХӨГЖҮҮЛЭЛТ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний соёлыг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх ажлын хүрээнд:

Нийгмийн даатгалын байгууллагаас 2022 оныг “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 тоот тушаалын хүрээнд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хийгдэх нийгмийн даатгалын багц хуулийн хэлэлцүүлэг, уулзалт, сургалтууд, байгууллагын санхүү, хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээний цахим системийг турших, нэвтрүүлэх ажлуудыг тусгасан 31 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж, төв, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэв.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор ОУХБ-тай хамтран хэрэгжүүлсэн “Албан бус эдийн засагт ажиллагсдын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх нь” төсөл энэ оны 2022 оны 1 дүгээр сард дуусаж байгаатай холбогдуулан зохион байгуулж гүйцэтгэсэн ажлын тайланг бэлтгэж, төслийн хөндлөнгийн үнэлгээний багтай 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр цахим уулзалт хийн тайланг танилцуулав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр “Ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” албан даалгавраар нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлуудыг тусган Аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-т хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/48 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын ажлын байранд ажлын байрны шинжилгээ хийж, ажлын ачааллыг тодорхойлох, ажлын байрны зураг авалтыг зохион байгуулах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст 2022 оны 03 дугаар сарын 28-наас 04 дүгээр сарын 07-ны өдрүүдэд ажиллан сайн дурын даатгалын байцаагч, сангийн нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэн, тасгийн дарга зэрэг албан хаагчдын ажлын байранд зураг авалт хийж, байцаагч ажилтнуудын ажлын ачааллыг тодорхойллоо. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/22, 2019 оны “Бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах тухай” А/131 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоог үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс баталсан “Албан тушаалын тодорхойлолт”-д заасан чиг үүргийн хэрэгжилтэд албан тушаал тус бүрээр дүн шинжилгээ хийв. Энэхүү ажлын байрны зураг авалтын дүнгээр ажлын хэсгээс нийгмийн даатгалын хэлтсүүд батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаж байгаа боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан дотоод зохион байгуулалтыг оновчтой хийн, ажлын ачааллыг тэнцвэржүүлэн байцаагч, ажилтнуудыг тодорхой хугацаанд шилжүүлэн ажиллуулах, нэг байцаагчид ногдох норм, нормативыг шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан болно.

Салбарын хэмжээнд нийт албан хаагчдаас 18 асуулт бүхий “Ажил үүргийн шинжилгээ хийх судалгаа”-г *Google Form* онлайн судалгааны програм ашиглан авсан бөгөөд уг судалгаанд 782 албан хаагч хамрагдсаны 533 албан хаагч нь аймгийн, 249 албан хаагч нь дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан, албан хаагчид байв. Асуумж судалгааны дүнгээс харахад салбарын хэмжээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголттой болох, нэг ойлголтоор хэрэгжүүлэх, албан хаагчдын нийгмийн асуудлыг анхаарах, хөдөлмөрийн хуулийн дагуу цайны цагтай болох, ажлын байрны орчинг сайжруулах, сумдын байцаагч нарын ажиллах орчинг сайжруулж интернет, тоног төхөөрөмж, програм хангамжуудыг сайжруулан хөгжүүлэх, уялдаа холбоог нь хангах норм, нормативыг ажлын байрны зураг авалтад тулгуурлан шинэчлэх, нормативын дагуу орон тоог батлан ажиллуулах асуудлыг шийдвэрлүүлэх талаарх саналууд дийлэнх хувийг эзэлж байсан.

Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/72 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/137 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн арга

хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг, А/73 дугаар тушаалаар "80 жилийн ойн бэлэгдэл (лого)-г" тус тус батлав. Мөн нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаа, ажилтнуудын чадавхийг сайжруулах, идэвхжүүлэх, иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилах зэрэг 24 ажлуудыг тусгасан төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллав.

"Нийгмийн даатгалын түүхэн замнал-80 жил" номонд оруулах нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, онцлох ажлуудын талаарх мэдээлэл, нийгмийн даатгалын салбарт олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001 стандарт нэвтрүүлж буй үйл ажиллагааны талаар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ын Шинрай төсөл хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл, "Нийгмийн даатгал 80 жилд" видео контентод нийгмийн даатгалын үйлчилгээ, чанарын удирдлагын менежментийг нэвтрүүлэх, ажлын байрны эмх цэгц, албан хаагчдын сахилга хариуцлага, ажлын цаг ашиглалт, хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх, шинэ санал санаачилгыг дэмжих, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчилах зорилгоор зохион байгуулах "80 жил-8 бүтээлч ажил" аяны удирдамжийг төв, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллалаа.

Төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой салбарын хэмжээнд мөрдөж буй эрх зүйн актын эмхтгэл, гарын авлагыг цахим хэлбэрээр бэлтгэв. Уг эмхэтгэлд төрийн албан хаагчийн ёс зүй, хэм хэмжээтэй холбоотой нийтлэг журам, нийгмийн даатгалын байцаагчийн мэргэшлийн зэрэг, улсын байцаагчийн шалгалт, үйлчилгээний хэм хэмжээ, стандарт, архив, албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой нийт 48 дүрэм, журам, зааврыг багтаасан бөгөөд салбарын нийт ажилтнууд өдөр тутмын ажилдаа гарын авлага болгон ашиглахад хялбар байдлаар бэлтгэлээ.

"Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг нь сэргээх, баталгаажуулах шалгалтын журам"-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал бэлтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 тоот тушаалаар шинэчлэн батлуулсан. Шинэчилсэн журам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/184 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/142 дугаар тушаалаар баталсан улсын байцаагчийн эрх олгох, эрх батагаажуулах, эрх сэргээх шалгалтын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Улсын байцаагчийн шалгалтын сорилын санг шинэчлэх, шинээр нэмж боловсруулах хуваарийг баталж, ерөнхий мэдлэгийн тест 1509, онол арга зүйн бодлого 500, ур чадварын шалгалтын 100 тестийг хянаж нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/160 дугаар тушаалаар батлуулан ерөнхий мэдлэгийн болон онол арга зүйн сорилын асуултыг дотоод сүлжээнд байршуулсан.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалттай холбоотой зөвлөмж, шалгалтын сорилын сантай холбоотой тайлбар, нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудаас болон магадлагч эмч нараас авах шалгалтын сорилын сангаас сонгох хууль, тогтоомжийн жагсаалт зэргийг боловсруулан холбогдох ажилтнуудад хүргүүлсэн.

Албан хэрэг хөтлөлтийн шалгалтыг дүгнэх хуудсыг улсын байцаагчийн акт боловсруулах шаардлага, бичвэрийн бүтцийг дүгнэх 13 үзүүлэлт, захирамжлалын баримт бичиг боловсруулах чадварыг дүгнэх 13 үзүүлэлт, албан бичиг боловсруулах

чадварыг дүгнэх 12 үзүүлэлтээр тус тус гаргасан ба акт бичих өгөгдлийг 30 хувилбараар, тушаалын төсөл боловсруулах өгөгдлийг 20 хувилбараар боловсруулан ажлын хэсгийн гишүүдэд хүлээлгэн өгсөн.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалт болон үйлдвэрлэлийн осол, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга зүйн сургалтыг бүсчлэн зохион байгуулахтай холбогдуулан үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах, сургалтад байцаагч, ажилтнуудыг зохион байгуулалттай, дэг журамтай, идэвхитэй оролцуулахтай холбоотой харилцааг зохицуулсан хариуцлагын гэрээг 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай байгуулав.

Улсын байцаагчийн шалгалтын ажлын хэсгийн хурлыг нийт 5 удаа, өргөтгөсөн хурлыг 2 удаа зохион байгуулан хуралдуулж, ажлын хэсэгт ирсэн 33 өргөдлийг журмын дагуу Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлэв.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалт зохион байгуулсан ажлын танилцуулгыг бэлтгэн улсын байцаагч (ахлах)-ийн шалгалтад тэнцсэн 339, шалгалт өгөлгүйгээр эрх сунгах 18, эрх түдгэлзүүлэх 40, эрх цуцлах 71 албан хаагчийн жагсаалтыг боловсруулан 2022 оны 01/2239 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын байгууллагаас иргэд, даатгуулагч, ажил олгогчдод үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран АХБ-ны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 21 аймаг, 8 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд “Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем”-ийг нэвтрүүлэн, киоск төхөөрөмжийг байршуулсан.

Төхөөрөмж (киоск)-өөр 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 28 аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 541 албан хаагч 81762 иргэд, даатгуулагчдад үйлчилгээ үзүүлэн, 10583 иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа аван ажилласан байна. Харин Хан-уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс огт ашиглаагүй, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс 1 удаа (мэдээллийн технологийн мэргэжилтэнгүй) ашигласан байна.

“Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам”-ын хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний соёл, байцаагч, ажилтнуудын харилцаа хандлагад судалгаа хийж, үнэлгээ өгөх зорилгоор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудын утсаар харилцах харилцаанд 10 удаагийн тандалт судалгаа хийхэд байгууллагын нэр, албан тушаал, өөрийн нэрийг хэлэхгүй байх зөрчил 30 хэлтсээс илэрч, мөн Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд нь лавлах утсаа огт авахгүй байсан зэрэг дутагдал гаргасан бөгөөд эдгээр илэрсэн зөрчлийг тухай бүр нь хэлтсийн удирдлагуудад мэдэгдэж залруулан ажиллав.

[Нийгмийн даатгалын байгууллагад Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэн, хэрэгжүүлэх ажлын талаар](#)

Нийгмийн даатгалын байгууллагад олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд Нийгмийн

даатгалын ерөнхий газар, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс аймаг, Багануур, Баянгол, Налайх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст ISO 9001:2015 стандартын талаар нийт 11 удаагийн сургалтыг “Удирдах урлаг хөгжил” ТББ-тай хамтран цахимаар болон танхимаар зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 760 албан хаагчдыг хамруулав.

ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын байгууллагын төлөв байдлыг тодорхойлох, үйлчилгээний чанарт тавих шаардлага, байгууллагын манлайлал, төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, сайжруулалтын чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийн удирдлага, ажилтнуудыг хамруулан 4 дэд баг байгуулан ажиллалаа.

Чанарын удирдлагын стандарт нэвтрүүлж буй Нийгмийн даатгалын ерөнхий газар, 8 аймаг, 6 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн нийт 83 албан хаагчдыг дотоод аудитын сургалтад 2022 оны 01 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд хамруулан, сертификат олголоо.

[Ажил олгогч, даатгуулагчдын санал хүсэлтийг сонсох, хүсэлт хүлээн авах чиглэлээр](#)

Иргэд, даатгуулагчийн санал хүсэлтийг цахим хэлбэр хүлээн авах, эргэх холбоо бий болгох чиглэлээр доорх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүллээ. Үүнд:

“Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө” фэйсбүүк хуудсанд нийгмийн даатгалтай холбоотой нийт 204 мэдээллийг зурган болон линк шэйрлэх хэлбэрээр орууллаа.

Тус фэйсбүүк хуудсанд хандсан хандалтыг тоон үзүүлэлтээр авч үзвэл:

№	Үзүүлэлт	Хүний тоо
1	Facebook хуудаст нэгдсэн	2923 /нийт 29 765/
2	Зөвлөгөө, мэдээлэлтэй танилцсан	351,700 /нийт 1 508 369/
3	Давтан үзсэн	102 /нийт 106 369/
4	Like буюу мэдээлэл таалагдсан	818 /нийт 27 724/
5	Comment буюу сэтгэгдэл үлдээсэн	193 /нийт 4734/
6	Share буюу бусдад түгээсэн	862 /нийт 10404/
7	Chat буюу зурвас хэлбэрээр харилцсан	1413 /нийт 15 660/

Фэйсбүүк хуудсыг дагаж байгаа иргэдийн дийлэнх нь 25-34 насныхан байгаа бөгөөд мэдээлэл авсан нийт иргэдийн 81 хувь нь буюу 24 110 нь эмэгтэй, 19 хувь нь буюу 5 655 нь эрэгтэй хүмүүс байна. Гадаад оронд ажиллаж амьдарч байгаа иргэд мөн холбогдох мэдээлэл, зөвлөгөө авч байгаагаас БНСУ-аас 378, Япон улсаас 138, АНУ-аас 87, Австрали улсаас 47, Бүгд Найрамдах Чех Улсаас 41, Шведээс 19, Туркээс 27, Ирландаас 24, Унгараас 21 иргэн холбогдсон байна.

Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө фэйсбүүк хуудасны автомат хариулагч буюу чатбот үйлчилгээнээс нийтдээ 440 хүн мэдээлэл, зөвлөгөө авсан ба үүнийг агуулгаар нь авч үзвэл дийлэнх нь тэтгэвэр, сайн дурын даатгалтай холбоотой мэдээлэл авсан байна.

“Нийгмийн даатгал” гар утасны аппликейшний хэрэглээг нэмэгдүүлэх, иргэд даатгуулагчдын санал хүсэлтэд тулгуурлан аппликейшнд нэвтрэх эрхийг цахимаар баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 3,555 иргэнд

баталгаажилтын нууц дугаарыг цахим хэлбэрээр олгон, 9490-1289, 9590-1289 дугаарын утсуудаар 1,402 иргэнд заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах утас (7777-1289)-аар нийт 113,329 иргэн үйлчилгээний ажилтантай холбогдож өөрт хамааралтай шаардлагатай мэдээ, мэдээллийг авсан бол автомат хариулагчаас 67,886 иргэн мэдээлэл, зөвлөгөө сонссон байна. Автомат хариулагчаас авсан мэдээллийг агуулгаар нь ангилж үзвэл тэтгэвэртэй холбоотой 7,020, тэтгэмжтэй холбоотой 27,106, сайн дурын даатгалтай холбоотой 6,727, ЭХМТК-той холбоотой 1,334, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 5,167, ажлын бус цагаар болон бусад асуудлаар 20,532 иргэн холбогдсон байна. Мөн автомат хариулагчийн мэдээллийг хуулинд орсон өөрчлөлтийн дагуу шинэчилсэн болно.

Нийгмийн даатгалын ерөнхий газарт цахимаар нийтдээ 5,803, үүнээс [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) вэбсайтын “Санал хүсэлт” буланд 178 санал хүсэлт, асуулт, “Нийгмийн даатгал” аппликейшнээр 5,085 санал хүсэлт, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 540 иргэдээс асуулт, хүсэлт ирүүлснийг ажлын 5 хоногт багтаан хүргүүлж ажиллалаа.

Ирсэн асуулт, санал хүсэлтийг агуулгаар нь ангилж авч үзвэл:

№	Санал, хүсэлтийн төрөл	Ирүүлсэн санал хүсэлт	
		тоо	хувь
1	Тэтгэвэртэй холбоотой	236	4.1
2	Тэтгэмжтэй холбоотой	1642	28.3
3	НД-ын болон ЭМД-ын шимтгэл төлөлттэй холбоотой	615	10.6
4	Сайн дурын даатгалтай холбоотой	939	16.2
5	Хүүхдээ асарч буй сайн дурын даатгуулагч эхийн шимтгэл төлөлттэй холбоотой	110	1.9
6	Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой	15	0.3
7	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данстай холбоотой	39	0.7
8	Нөхөн даатгалтай холбоотой	111	1.9
9	Шимтгэлийн 50%-ийн буцаан олголттой холбоотой	685	11.8
10	“Нийгмийн даатгал” аппликейшнтэй холбоотой	988	17.0
11	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, байцаагчтай холбоотой	17	0.3
12	Талархал	30	0.5
13	Дүүргийн НДХ-үүд утсаа авахгүй байгаа талаар	99	1.7
14	Бусад асуудлаар	277	4,7
<b>НИЙТ ДҮН</b>		<b>5803</b>	<b>100</b>

### 1.1.2. ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛ

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймаг, нийслэлийн Багануур, Сүхбаатар дүүргийн ЭХМК-ын нийт 20 иргэний амбулаторийн картын бичилт, оношийн баталгаажуулалт, ЭХМК-ын хурлын шийдвэр зэрэгт “Ижил мэргэжилтний үзлэг” зохион



байгуулж, 2022 оны 06 сарын 09-ний өдөр цахим хэлбэрээр хэлэлцүүлэв. Хэлэлцүүлэгт ЭХМТК болон ижил мэргэжилтний үзлэгт оролцсон аймаг, дүүргийн ЭХМК, ЭХК-ын магадлагч эмч, төрөлжсөн мэргэжлийн нийт 30 орчим эмч, мэргэжилтнүүд оролцов.

Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, эрдэм шинжилгээ, судалгаа хийх зорилгоор Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 67 дугаар тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2 дахь хэсгийн 2.10-2.15, 2.17 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/166 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах журам”-ыг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилох шалтгаан болж буй мэдрэл, сэтгэц, дотор, гэмтэл согогийн өвчний чиглэлээр Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмч нарын сонгон шалгаруулалтыг 2015 оноос эхлэн 3 жил тутамд зохион байгуулж, томилон ажиллуулж байна. Тус газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дотор, мэдрэл, сэтгэц, гэмтлийн мэргэжлийн шинжээч эмч нарын хугацаа дуусгавар болж 2022 оны 01 дүгээр сард дээрх төрөлжсөн мэргэжлийн эмч нарын сонгон шалгаруулалтыг зарлав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/05 дугаар тушаалаар Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмчийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмчээр дараах мэргэжлийн эмч нарыг сонгон шалгаруулж, Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2 дахь хэсгийн 2.2.2, 2.17 дахь заалтуудыг үндэслэн сонгон шалгаруулалтын дүнгийн танилцуулга болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмч нарын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох саналыг Нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулав.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүнд ажиллах төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үйл ажиллагааг мэргэжил аргазүйн удирдлагаар ханган, сонгон шалгаруулалтаар ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч хянаж, шалган сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг хангасан комиссын гишүүдийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар шинэчлэн томилуулж тушаалыг хүргүүлэв.

#### [Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр:](#)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор эмнэлгийн хуудас бичих, илгээх, хяналт тавих явцыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж, олгож байна. Өнөөдрийн байдлаар нийт анхан шатны 602, 2, 3 дахь шатлалын 99, хувийн хэвшлийн 148, нийт 850 орчим эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн хуудсыг цахимаар бичин олгож байгаа бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдсан нийт 105,996, жирэмсэн амаржсаны нийт 46,257 иргэний тэтгэмжийг цахимаар хүлээн авч хянан баталгаажуулж олгосон байна.

Туршлага солилцох цахим хурлыг Баян-Өлгий, Орхон, Дархан, Сүхбаатар, Багануур дүүргүүдийг хамруулан 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулав. Тус хуралд Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга, гишүүд нийт 40 гаруй эмч мэргэжилтнүүд оролцов. Сургалтаар Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийн танилцуулга, хурлын онцлог дэг журам, өрөө тасалгааны зохион байгуулалт, тохижилт, хурлын үеэр авч хэрэгжүүлж буй онцлог зүйлс, 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлын товч тайлан, 2022 оны эхний хагас жилийн хурлын тоон үзүүлэлт, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт”-тай холбоотой тодруулга, мэдээлэл, санал зэргийг солилцов. Тус хурлын үеэр гэмтэл, мэдрэл, дотрын өвчний 9 иргэний амбулаторийн карттай танилцаж, харилцан туршлага солилцон ажиллав.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нарийн бичгийн дарга болон магадлагч эмч нар Сэтгэцийн болон Мэргэжлээс шалтгаалах өвчний салбар комиссын 68 удаагийн хуралд оролцож 2,772 иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоохтой холбоотой асуудлыг шийдвэрлэв.

Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс ХДХВ, ДОХ-той иргэдийн бүртгэл, мэдээлэл, тусламж үйлчилгээний талаар болон уг өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн нууцлалын талаар 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, нийслэлийн дүүргүүдийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төлөөлөл оролцсон уулзалт хэлэлцүүлэгт нийт 40 орчим эмч мэргэжилтнүүд оролцож, мэдээлэл солилцов.

“Анхан шатны баримт бичгийн хөтлөлтийг сайжруулах” аяныг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулав. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос тус аяны хүрээнд Хан-Уул дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд 2 удаа, Эмнэлэг хяналтын комиссын хуралд 2 удаа оролцож, эмнэлэг хөдөлмөр магадлалын тушаал шийдвэрийн хэрэгжилтийн байдалд хяналт хийн, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар зөвлөгөө өгч ажиллав. Аяны хугацаанд Хан-Уул дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын дунд 80 иргэний амбулаторийн карт дахь үечилсэн дүгнэлт, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, 40 иргэний амбулаторийн картад ижил мэргэжилтний үзлэг хийлгэж, зөвлөгөө өгч ажиллав. Тус ижил мэргэжилтний үзлэгт нийт өрхийн эрүүл мэндийн төвийн 7 эмч хамрагдав.

#### Хяналт шалгалтын чиглэлээр:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос дахин магадлал зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн дагуу Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын магадлагч эмч нар Сүхбаатар дүүрэг болон Сүхбаатар, Говь-Сүмбэр, Дорноговь, Баянхонгор Баян-Өлгий аймгуудад хяналт шалгалтыг зохион байгуулав. Нийт 5 удаагийн дахин магадлалаар дээрх аймаг, дүүргүүдийн нийт 1,406 иргэнийг дахин магадлаж үүнээс, 1,025 /79.2%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадлан, 332 /26.3%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын заалт, хувь, хугацааг өөрчилж, 49 /4%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцлахаар шийдвэрлэв.

Говьсүмбэр аймгийн дахин магадлалыг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулав. Говьсүмбэр аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон 522 иргэн /даатгуулагч/ байгаагаас 306 (58.6%)-ийг шалгалтад хамрагдсан байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоосон нийт 306 иргэний амбулаторийн картыг шалгахаас 272 иргэнийг буюу 89.5 хувийг хамруулсан байна.

Эмнэлэг хяналтын комисс болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдтэй уулзалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Дахин магадлалын явцад эмнэлгийн хуудасны бичилт олголтод хяналт тавьж ажиллав. Тус аймгийн хувьд 2 өрхийн эрүүл мэндийн төвтэй аймгийн эрүүл мэндийн газрын статистикч эмч эмнэлгийн хуудсыг бичиж байсан бөгөөд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Дорноговь аймгийн дахин магадлалыг 2022 оны 05 дугаар сард дахин магадлалыг зохион байгуулав. Чих хамар хоолой-18, Мэдрэл-31, Дотор-37, Гэмтэл-28, Мэс засал-29, Нүд-9, Халдварт-7, Эх барих-1, Сэтгэц-8 эдгээр 9 төрлийн нийт 168 иргэдийн амбулаторийн картыг татаж, шаардлагатай тохиолдолд биеэр дуудаж хяналт шалгалтыг зохион байгуулав.

Сүхбаатар аймгийн дахин магадлалыг 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 02 дугаар сарын 22-ны өдрүүдэд зохион байгуулав. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь Ковидын халдварын нөхцөл байдлын улмаас хурлын байр байхгүй түр хугацаагаар Нэгдсэн эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч даргын өрөөнд хуралдаж байна. Нийгмийн даатгалын хэлтэс магадлагч эмчгүй байна. Хөдөлмөрийн чадвар алдсан 110 иргэн (даатгуулагч)-ийг хамруулахаар төлөвлөсний дагуу 100 хувь хамруулав. Нийт 99 иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг хэвээр дахин магадлаж, хяналтыг сайжруулах 7, 2 иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг дахин сунгахгүй цуцлахаар магадлав.

Сүхбаатар дүүргийн дахин магадлалыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулав. Хөдөлмөрийн чадвар алдсан 293 иргэн (даатгуулагч)-ийг хамруулахаар төлөвлөсний дагуу 100 хувь хамруулав. Нийт 285 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг хэвээр дахин магадлаж, хяналтыг сайжруулах 4, заалт өөрчлөн сунгах 2, 2 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг дахин сунгахгүй цуцлахаар магадлав. Тус хэлтсээс 2022 оны 01 дүгээр сараас 04 дүгээр сарыг хүртэл хугацаанд 3 ба түүнээс дээш удаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан 86, жирэмсний тэтгэмж олгосноос 30 хүртэл хоногийн дотор амаржсаны тэтгэмжийг олгосон 55 даатгуулагчийн эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэл, тэтгэмжийн эрх үүсгэх зорилгоор жирэмсний эмнэлгийн хуудсыг хойшлуулж олгосон эсэхэд нийгмийн даатгалын байгууллагын архивын баримт, Тэтгэмжийн программ, Эрүүл мэндийн байгууллагын цахим мэдээллийн сангийн бүртгэл, E Health, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгосон бүртгэл, жирэмсний хяналтын карт, Эмнэлэг хяналтын комиссын хурлын бүртгэл зэрэгт тулгуурлан шалгахад зөрчил илрээгүй болно. Тус дүүргийн хэмжээнд магадлагч эмч хянаагүй 722, аж ахуйн нэгж хянаагүй 933, хяналтын байцаагч хянаагүй 25 эмнэлгийн хуудсыг хянаж, тэтгэмжийг олгох ажилд хэлтсийн бусад ажилтнуудыг татан оролцуулж, шуурхай зохион байгуулахыг үүрэг болгон, хяналт тавин ажиллав.

Баянхонгор аймгийн дахин магадлалыг 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 6 дугаар сарын 19-ны өдрүүдэд зохион байгуулав. Дахин магадлалын хугацаанд нийт 1,036 иргэний тахир дутуугийн хувийн хэрэгт дахин магадлал хийж үүнээс, 970 /93.6%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадлан, 66 /6.3%/ иргэнийг биеэр

байлцуулан хөдөлмөрийн чадвар алдалтын заалт, хувь, хугацааг холбогдох шинжилгээ оношилгоог хийлгэсний дараа шийдвэрлэх чиглэл өгч ажиллав. Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх Эмнэлэг хяналтын комисс, Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдтэй уулзалт зохион байгуулж, 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд оролцож, дотоод ажилтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Баян-Өлгий аймгийн хөдөлмөрийн чадвар алдсан 148 даатгуулагч (иргэн)-ийг хамруулахаар төлөвлөснөөс 147 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр дахин магадлаж, хяналтыг сайжруулах 7, 1 иргэний заалт өөрчлөн сунгахаар магадлав.

Ховд, Архангай, Дорнод аймгуудад Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтран хяналт, шалгалтыг зохион байгуулав.

Хамтарсан магадлалаар нийт хөдөлмөрийн чадвар алдсан 2493 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 1430 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 223 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 773 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж магадлав.

Ховд аймгийн хамтарсан магадлалыг 2022 оны 09 дүгээр сарын 11-нээс 09 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулав. Хамтарсан магадлалаар хөдөлмөрийн чадвар алдсан 770 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 429 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 57 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 300 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж, 29 иргэнийг шинжилгээнд хамруулж магадлав.

Дорнод аймгийн хамтарсан магадлалыг 2022 оны 09 сарын 21-нээс 09 дүгээр сарын 30-ний өдрийн хугацаанд зохион байгуулав. Хамтарсан магадлалаар хөдөлмөрийн чадвар алдсан 952 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 606 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 78 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 185 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж, 107 иргэнийг шинжилгээнд хамруулж магадлав.

Архангай аймгийн хамтарсан магадлалыг 2022 оны 10 сарын 16-наас 10 сарын 26-ны өдрийн хугацаанд зохион байгуулав. Хамтарсан магадлалаар хөдөлмөрийн чадвар алдсан 771 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 395 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 88 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 288 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж магадлав.

Нийслэлийн Багануур, Сүхбаатар дүүрэг, Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын цахим мэдээллийн санд бүртгэлтэй 15,800 гаруй иргэний мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээг хөдөлмөрийн чадвар алдалт тогтоосон өвчний заалт өвчний нэр зөрүүтэй 103 /0.7%/, 3 ба түүнээс дээш жил ажилласан нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч 301 /1.9%/, 3-аас доош жил ажилласан нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 35 /0.2%/, зэрэг

давхардсан тоогоор нийт 439 /2.8%/ зөрчил, дутагдал илэрснийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Аймаг, дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтсүүдээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны 7,649, жирэмсэн амаржсаны 8,779 орчим иргэнд эмнэлгийн хуудасны тэтгэмж олгосон байдалд цахимаар хяналт хийв. Үүнээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 3 ба түүнээс дээш удаагийн давтамжтай авсан, тэтгэмж олгосон мөнгөн дүн тодорхойгүй зэрэг давхардсан тоогоор 100 орчим даатгуулагчид олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний эмнэлгийн хуудсыг тэтгэмжийн эрх үүсгэх зорилгоор хойшлуулж олгосон байж болзошгүй 150 гаруй даатгуулагч эхэд олгосон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн үндэслэлийг Эрүүл мэндийн байгууллагад нягтлан шалгах хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулан ажиллав.

Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар, Дорноговь, Ховд, Дорнод аймаг, Говьсүмбэр аймаг, нийслэлийн, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны 5,400, жирэмсэн амаржсаны 6,300 орчим иргэнд эмнэлгийн хуудасны тэтгэмж олгосон байдалд цахимаар болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин магадлалаар хяналт хийв. Үүнээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 3 ба түүнээс дээш удаагийн давтамжтай авсан, тэтгэмж олгосон мөнгөн дүн тодорхойгүй зэрэг давхардсан тоогоор 100 орчим даатгуулагчид олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний эмнэлгийн хуудсыг тэтгэмжийн эрх үүсгэх зорилгоор хойшлуулж олгосон байж болзошгүй 180 гаруй даатгуулагч эхэд олгосон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн үндэслэлийг Эрүүл мэндийн байгууллагад нягтлан шалгах хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулж ажиллав. Эмнэлгийн хуудасны цахимжуулалтын байдалтай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Орон нутаг болон салбар комиссын хурлын мэдээг аймаг, дүүрэг тус бүрээр авч 7 хоног бүр нэгтгэн удирдлагад танилцуулан ажиллаж байна. Үүнд 21 аймаг, нийслэлийн 8 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссууд 2022 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн жилийн эцсийн байдлаар цахим болон бичиг баримтад үндэслэж зохион байгуулсан 1,258 удаагийн хурлаар 9,820 иргэнд шинээр, 6,665 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж, 69,655 иргэнийг хэвээр сунгаж, бичиг баримт дутуу 1,731 иргэнийг буцааж, нийт 88,123 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн байна.

### **1.1.3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

[Салбарын хэмжээнд ашиглагдаж буй програм хангамжуудын хэвийн найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай өөрчлөлт хөгжүүлэлт хийх](#)

*Шинээр 3 систем, 15 сервис боловсруулан нэвтрүүлээ.*

УИХ-аас шинээр баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай” хууль, Засгийн Газрын 2022 оны “Журам батлах тухай” 230 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Refund50-Core” системийг шинээр боловсруулан нэвтрүүлээ. /2.3-д дэлгэрэнгүй дурдсан/

Төв орон нутгийн нийгмийн даатгалын байцаагч, ажилтнууд сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголттой холбоотой мэдээллүүдийг харах, хянах, даатгуулагч, ажил олгогчийг мэдээллээр хангах зориулалтаар ашиглах “Refund50” вэб програм хангамж боловсруулан нэвтрүүлээ. /2.3-д дэлгэрэнгүй дурдсан/

Эмнэлгийн хуудас цахимжсантай холбогдуулан төв, орон нутгийн магадлагч эмч нар эрүүл мэндийн байгууллагаас илгээж буй эмнэлгийн хуудасны бичилт, олголт болон бусад дэлгэрэнгүй мэдээллийн үнэн зөв байдлыг шалгах “Medical Monitor” вэб програм хангамжийг боловсруулан нэвтрүүлээ. Уг програм хангамжаар нийтдээ 163.0 мянган эмнэлгийн хуудасны мэдээллийг нягтлан шалгасан байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн үйлчилгээг цахимжуулахтай холбогдуулан төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 10 төрлийн, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-д 5 төрлийн сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн.

*Програм хангамжуудад 110 гаруй удаагийн өөрчлөлт, сайжруулалт хийлээ.*

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Тэтгэврийн тооцооны програм хангамж”-д дор дурдсан өөрчлөлтүүдийг оруулж, 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн олгох боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Үүнд:

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон авч буй нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэх;

- Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн, түүнчлэн цэргийн алба хаасны бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 500000, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400000 төгрөгөөр тус тус тооцох;

- Тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэхэд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400000 төгрөгт хүрэхгүй тохиолдолд шинэчлэн тогтоосон доод хэмжээнд тус тус хүргэж нэмэгдүүлэх.

Эдгээр боломжийг бүрдүүлснээр нийтдээ 462.5 мянган тэтгэвэр авагч тэтгэврээ нэмэгдүүлэн авсан байна.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа”-ны жагсаалтыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхтэй холбогдуулан эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын бүртгэлийн програмд уг жагсаалтыг шинэчлэн оруулсан.

Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ өргөжиж байгаатай уялдуулан ажил олгогчдын хүний нөөцийн ажилтан нь ажилтнуудынхаа хөдөлмөр эрхлэлтийн хөдөлгөөнийг цахимаар бүртгэх, мөн эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн хөдөлмөрийн чадвар алдалтын эмнэлгийн хуудасны холбогдох мэдээллийг бүртгэх шаардлага үүссэн. Үүнтэй холбогдуулан “Шимтгэлийн цахим систем”-д ажил олгогчийн хүний нөөцийн ажилтан тусдаа эрхээр нэвтэрч зөвхөн тушаал, эмнэлгийн хуудас цэсэнд ажиллах боломжийг бүрдүүлсэн. Мөн “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлчилгээний газрын хүсэлтээр олон тооны ажилтантай байгууллагын хүний нөөцийн ажилтанг өөрийн хариуцсан нэгжийн ажилтны тушаал болон эмнэлгийн хуудаст хандах нөхцөлийг бүрдүүлсэн. Эдгээр боломжийг бүрдүүлснээр энэ онд нийт 443 ажил олгогчийн 497 хүний нөөцийн ажилтан 125.6 мянган тушаалын мэдээллийг бүртгэсэн байна.

“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай” хуулиуд 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн

бөгөөд хуульд хувь хүний мэдээллийг цахим орчинд ашиглахдаа тухайн иргэнээс зөвшөөрөл авах, хаанаас, ямар мэдээлэл дуудаж буй талаар иргэнд мэдэгдэх харилцааг зохицуулж өгсөн. Үүнтэй уялдуулан даатгуулагчийн улсын бүртгэлийн мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сангаас шалгах зорилгоор нийгмийн даатгалын салбарт ашиглагдаж буй “Regweb” програм хангамжид холбогдох өөрчлөлтийг оруулж нэвтрүүлсэн.

Эмнэлгийн хуудас, ажилгүйдлийн тэтгэмж, сайн дурын даатгалын, ажил олгогчийн шимтгэлийн цахим систем болон цахим архив, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар Нийслэлийн төвийн 6 дүүргээс 130 орчим санал ирүүлсэн. Эдгээрийг нэг бүрчлэн судалж, зайлшгүй шаардлагатай 22 санал гарснаас 18 саналыг холбогдох програм хангамжуудад өөрчлөлт сайжруулалтыг хийж шийдвэрлэсэн.

“Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг эрэгтэй даатгуулагчийн хувьд 15 жил, эмэгтэй даатгуулагчийн хувьд 22 жил байх өөрчлөлтийг “Тэтгэврийн тооцооны програм хангамж”-д оруулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/109 дүгээр тушаалаар даатгуулагчийн төрлийн кодыг шинэчлэн баталсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын даргын 2022 оны 05/1316 тоот албан бичгээр ирүүлсэн даалгаврын дагуу даатгуулагчийн төрөл дээр дор дурдсан кодуудыг шинээр нэмж, шимтгэлийн хувь хэмжээг тохируулах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- “68 - Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого авсан хүүхдээ асарч байгаа эх”-ийн шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогчоос 12.5%-14.5%, даатгуулагчаас 11.5%, нийтдээ 24.0%-26.0%-иар тооцох;

- “69 - Цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон цэргийн алба хаагч”-ийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс хариуцан төлөх тул хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нь зөвхөн ажил олгогчийн тухайн сарын хөдөлмөрийн хөлсний санд оруулан тайлагнах тохиргоо хийх;

“Даатгуулагчийн үндсэн ажил олгогчоос гадна нэгээс дээш байгууллагад ажиллан илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох аргачлал”-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газраас жагсаалтаар ирүүлсэн 2021 оны илүү төлсөн шимтгэлээ буцаан авах эрх нь үүссэн нийт 10,832 даатгуулагчийн мэдээллийг бүх нэгжийн мэдээллийн санд байршуулж, даатгуулагчдад илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох боломжийг бүрдүүлсэн.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалт авахтай холбоотой “Зайн сургалт” вэб програм хангамжид байцаагч, ажилтнуудын мэдээлэл, шалгалтын 2190 асуулт, 8760 бодлогын текстийг хөрвүүлэн оруулж, дүнгийн хуудсыг хэвлэх боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд шалгалтад хамрагдсан 443 байцаагч, ажилтнуудын ерөнхий мэдлэгийн шалгалтыг аван дүгнэж, бүх үйл ажиллагааг хувь хүний оролцоо, нөлөөлөлгүйгээр системээр амжилттай зохион байгуулсан.

*Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санг баяжуулан хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.*

Салбарын 30 нэгжийн мэдээллийн санг өдөр бүр цахимаар цуглуулан нэгтгэж нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажлыг тасралтгүй, тогтмол гүйцэтгэн ажиллалаа. Энэ

онд ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчийн дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан 82.3GB нэгдсэн мэдээллийн сан үүссэн байна.

*Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод мэдээллийг 4 сувгаар цахимаар тогтмол хүргэж байна.*

Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн “ХУР” системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар хүргэх ажил тогтмол, хэвийн явагдлаа. Тухайлбал:

- "Нийгмийн даатгал" аппликейш нийг нийтдээ 250.0 мянга орчим даатгуулагч өөрийн шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн мэдээллээ харах, сайн дурын даатгалын үйлчилгээнд хамрагдах зэргээр идэвхтэй ашиглаж байна.

- “Даатгуулагчид зориулсан вэб” системийг ашиглан нийтдээ 69.9 мянга даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд хамрагдсан байна.

“Даатгуулагчид зориулсан вэб” систем, “Нийгмийн даатгал” аппликейшн, “Нэгдсэн лавлагааны програм”-аас нийтдээ 2.4 сая орчим QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолт авсан байна.

- Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаар үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэн даатгуулагч 2000-2005 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авах боломжийг нэмж бүрдүүлсэн. Энэ онд 156.9 мянган иргэн ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан байна.

- Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-гаар хүргэж буй үйлчилгээг өргөжүүлэн дараах боломжуудыг бүрдүүллээ. Үүнд:

- Хөдөлмөрийн чадвар түр алдалтын, жирэмсэн болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтээ цахимаар гаргах;

- Тэтгэвэр тогтоолтын тодорхойлолтоо цахимаар авах;

- Нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийн буцаан олголт авах дансны дугаараа бүртгүүлэх, засах.

Иргэд даатгуулагч, ажил олгогч уг порталаас нийгмийн даатгалын 11 төрлийн үйлчилгээг авч байгаа бөгөөд үүнээс 4 төрлийн лавлагаа тодорхойлолтыг англи хэл дээр авч байна. Мөн иргэд, даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагуудад өгсөн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцаа цахимаар харах, хянах боломжийг бүрдүүлснээр энэ оны эхний 11 сарын байдлаар нийт 6.7 мянган иргэний өргөдөл бүртгэгдэж, холбогдох мэдээллийг иргэнд мессежээр илгээсэн байна.

[Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2022 онд хэрэгжих өөрчлөлтийг мэдээллийн технологиор дэмжин ажиллах](#)

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19<sup>2</sup> дүгээр зүйлийн 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх нь үүссэн, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш ихэр хүүхэд төрүүлсэн эхэд амаржсаны тэтгэмж олгох хугацааг 80 хоногоор тооцох өөрчлөлтийг “Тэтгэмжийн тооцооны програм хангамж”-д оруулж нэгжүүдийг програм хангамж ашиглах боломжийг бүрдүүлсэн. Энэ онд нийтдээ 189 эх уг хуулийн үйлчлэлд хамрагдсан байна.

[Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны эцсийн үлдэгдлийн тооцооллыг хийж, иргэд даатгуулагч цахимаар харах, хэвлэн авах боломжийг бүрдүүлэх](#)



Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 21 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын даргын 2022 оны 05/29 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн нийт 1554.1 мянган даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдлийн тооцооллыг хийсэн.

Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны эцсийн үлдэгдлийн мэдээллийг “Даатуулагчид зориулсан вэб”, E-MONGOLIA портал, “Нийгмийн даатгал” аппликейшн зэрэг цахим сувгуудад байршуулан иргэд цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. Мөн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд хүсэлт гаргасан даатгуулагч болон ажил олгогчид хэвлэн өгөх боломжтой.

#### [Судалгаа, тооцооллын талаар:](#)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/99 дүгээр тушаалаар баталсан заавар, мөн газрын “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/1168 тоот албан бичгийн дагуу 5-10 дугаар саруудын байдлаар буцаан олголттой холбоотой 22 төрлийн томоохон судалгаа тооцооллыг нийт 6 удаа хийж, хууль тогтоомжийн хэрэгжилт цаг хугацаандаа явагдах нөхцөлөөр ханган ажиллалаа. Үүнд:

- Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, төлсөн шимтгэлийн дүнг тооцоолж даатгуулагч нь хуулийн үйлчлэлд хамрагдах ажил олгогчийн мэдээллийг шинэчлэн гаргах;

- Хуулийн нөхцөл хангасан албан журмын даатгуулагчдын буцаан олголтын мэдээллийг гаргах;

- Сайн дурын даатгуулагч, сайн дурын даатгуулагч эхийн төлсөн шимтгэлийн дүнг тооцоолж хуулийн үйлчлэлд хамаарах даатгуулагчийн судалгааг шинэчлэн гаргах;

- Дансгүй, овог, нэр зөрсөн даатгуулагчдын мэдээллийг аймаг, дүүргээр гарган нэгжүүдэд дансжуулахаар хүргүүлэх;

- Сангийн яамнаас эцэслэн хийгдсэн гүйлгээ болон гүйлгээ нь буцаагдсан даатгуулагчдын мэдээллийг аймаг, дүүргээр болон 4 сангаар гаргах;

Хуулийн үйлчлэлд хамрагдан буцаан олголт авах нөхцөл хангасан даатгуулагчдын жагсаалтыг 2022 оны 5-10 дугаар сарын байдлаар буцаан олголт олгох 621.0 мянган даатгуулагчийн дансны мэдээллийг Монгол банкны дансны нэгдсэн системтэй тулган шалгаж, давхардсан тоогоор нийт 1766.9 мянган даатгуулагчид буцаан олголт олгосон байна.

#### **[1.1.4. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ](#)**

##### [Сургалтын арга зүйг сайжруулах чиглэлээр](#)

2022 оныг “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” болгон зарласантай холбоотой нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах, сургалт зохион байгуулах ажлын чиглэлийг салбарын нийт хэлтсүүдэд тухай бүр хүргүүлэн ажиллалаа.

Салбарын хэмжээнд албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх 1,046 удаагийн сургалт (давхардсан тоогоор)-ыг зохион байгуулж 21,678 албан хаагчийг хамруулав (Хавсралт 1). Үүнд:

Байгууллагын нэр	Тоон дүн	
	Зохион байгуулсан сургалтын тоо	Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Архангай	91	1374
Баян-Өлгий	20	300
Баянхонгор	61	708
Булган	23	568
Говь-Алтай	52	331
Говьсүмбэр	12	108
Дархан-Уул	27	781
Дорнод	7	84
Дорноговь	20	458
Дундговь	3	29
Завхан	40	1038
Орхон	80	766
Өвөрхангай	26	464
Өмнөговь	27	292
Сүхбаатар	34	459
Сэлэнгэ	54	500
Төв	31	748
Увс	22	375
Ховд	18	540
Хэнтий	27	468
Хөвсгөл	25	1054
Багануур дүүрэг	32	284
Багахангай дүүрэг	13	408
Баянгол дүүрэг	54	730
Баянзүрх дүүрэг	13	15
Налайх дүүрэг	59	324
Сонгинохайрхан дүүрэг	28	448
Сүхбаатар	33	597
Хан-Уул дүүрэг	16	471
Чингэлтэй дүүрэг	30	241
Нийслэлийн Нийгмийн даатгалын газар	18	454
Нийгмийн даатгалын ерөнхий газар	50	6261
<b>Нийт</b>	<b>1,046</b>	<b>21,678</b>

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 50 удаагийн сургалтыг зохион байгуулж салбарын 6261 (давхардсан тоогоор) албан хаагчийг дараах сэдвийн хүрээнд хамруулав.

[Ажил олгогчид, даатгуулагчид, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах ажлын хүрээнд](#)

Салбарын хэмжээнд ажил олгогч, иргэд даатгуулагчид чиглэсэн 3,299 удаагийн танхимын болон цахим сургалтад 13,949 аж ахуйн нэгжийн 241,533 иргэд, даатгуулагчийг хамруулав. Үүнд:

Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад зориулсан 314 удаагийн цахим сургалтад 6,004 аж ахуйн нэгжийн 12,660 иргэд даатгуулагчийг хамруулсан байна.

Байгууллагын нэр	Тоон дүн		
	Аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Зохион байгуулсан сургалтын тоо	Хамрагдсан хүний тоо
Архангай	228	228	11090
Баян-Өлгий	40	45	2100
Баянхонгор	108	108	79220
Булган	25	20	4633
Говь-Алтай	522	264	10315
Говьсүмбэр	35	18	1097
Дархан-Уул	447	50	2521
Дорнод	272	411	8659
Дорноговь	91	56	5454
Дундговь	28	19	242
Завхан	170	42	1928
Орхон	269	88	7224
Өвөрхангай	283	91	4694
Өмнөговь	42	60	2261
Сүхбаатар	504	219	7264
Сэлэнгэ	20	25	1473
Төв	1099	519	18977
Увс	74	71	4778
Ховд	120	12	11529
Хэнтий	677	324	18045
Хөвсгөл	367	28	1306
Багануур	3	3	371
Багахангай	1132	13	1404
Баянгол	828	73	7060
Баянзүрх	20	7	265
Налайх	22	22	1574
Сонгинохайрхан	122	19	1955
Сүхбаатар	178	11	855
Хан-Уул	39	18	1787
Чингэлтэй	72	13	1140
Нийслэлийн Нийгмийн даатгалын газар	91	91	6305
Нийгмийн даатгалын ерөнхий газар	6021	331	14007
<b>Нийт</b>	<b>13,949</b>	<b>3,299</b>	<b>241,533</b>

Түүнчлэн, 2022 онд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 892 удаагийн явуулын үйлчилгээг зохион байгуулж 94,677; 187 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгт 51,706 иргэд, даатгуулагчдыг тус тус хамруулж, нийт 15,056 иргэдэд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.

### ***ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХҮРЭЭНД***

#### ***Нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах чиглэлээр***

Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч талуудад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээллийг тогтмол ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор гарын авлага, сурталчилгааны хуудсыг олон нийтийн

сүлжээ, явуулын үйлчилгээ, өдөрлөг болон хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран түгээж ажиллав. Үүнд:

Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээний мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын @sigomongolia сошиал хуудсаар 7 заавар, гарын авлага, 53 постер мэдээлэл, 4 шторк, 71 удаагийн цаг үеийн буюу нийт 133 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн үйлчилгээг цахимаар үзүүлж эхэлсэнтэй холбогдуулан 1 видео, 5 гарын авлагыг шинээр боловсруулан иргэд, даатгуулагч, ажил олгогч, эрүүл мэндийн байгууллагад цахим хэлбэрээр түгээсэн (давхардсан тоогоор 627,764 хүнд хүрсэн);

- Нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон 2022 оноос хэрэгжиж байгаа өөрчлөлт, цахим үйлчилгээний талаарх 32 постер мэдээллийг түгээж давхардсан тоогоор 2.8 сая хүнд хүрсэн;

- Нийгмийн даатгалын байгууллагын танилцуулга номыг шинэчлэн боловсруулж, цахим хэлбэрээр түгээсэн;

- Монголын хуульчдын холбоо болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хууль зүйн нээлттэй өдөрлөгт төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагууд оролцов.

### [Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах чиглэлээр](#)

Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн мэдээллийг “ТВ9”, “ТВ6”, “ТВ8”, “С1”, “МН25”, “Ийгл”, “Парламент”, “Өлзий”, МҮОНРТ-ийн “ММ”, “Хурд”, “Соёмбо” агентлаг, “Малчин”, “Монгол HD”, “Стар”, “UBS”, “ETV”, “NTV”, “Тэнгэр” телевиз, “news.mn”, “itoim.mn”, “zarig.mn”, “zaag.mn”, “arслан.mn”, “ikon.mn”, “ulsturch.mn”, “ubn.mn”, “face.mn” вебсайт, “өглөөний сонин”, “өдрийн сонин”, “өнөөдөр сонин”, “монголын үнэн сонин” зэрэг 81 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан давхардсан тоогоор 578 удаагийн давтамжтайгаар иргэд, даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр хангав.

“Гэрэл плас медиа групп” ХХК, “Өглөөний сонин” ХХК, “Улстөрч” агентлаг, “Улаанбаатар ньус” ХХК, “Монголын үнэн” сонин, “Ган үзэгтэн” ХХК, “Суваг ти ви найм” ХХК, “Энх Арслан” ХХК зэрэг 8 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээний мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллаж байна.

### [Олон нийтийн асуулт, санал хүсэлтэд хариулах, эргэх холбоог хангах чиглэлээр](#)

Иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор @sigomongolia сошиал хуудсанд чатбот мессенжерийг ажиллуулж байна. Тайлант хугацаанд чатбот мессенжерт нийт 75,519 иргэн мэдээлэл авахаар хандсанаас 60,738 иргэн автомат хариулагчаас мэдээлэл авсан бол 11,125 иргэн тухайлсан зөвлөгөө мэдээлэл авахаар, 2,619 иргэн бусад асуудлаар, 1,037 иргэн санал, гомдлоо илэрхийлж хандсаныг тухай бүр шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын байгууллагын сошиал хуудас @sigomongolia-д 3,500 орчим иргэн сэтгэгдэл, санал хүсэлтээ илэрхийлснийг тухай бүр хариулан, санал гомдлыг холбогдох газарт шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллав.

## **ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД**

[Гадаад орны нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр](#)

Бүгд найрамдах Солонгос улсын Үндэсний тэтгэврийн албатай хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлүүдийг англи, монгол хэл дээр боловсруулж, хамтран ажиллах саналыг Үндэсний тэтгэврийн албаны Олон улсын харилцааны төвд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 01/254 дүгээр албан бичгээр, Монгол Улсад БНХАУ-аас суугаа Элчин сайдын яамтай хамтран ажиллах саналыг Элчин сайдын яамны Худалдаа эдийн засгийн газарт 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 01/360 дугаар албан бичгээр, Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлагтай хамтран ажиллах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/380 дугаар албан бичгээр, Фредрих Эбертийн сантай хамтран ажиллах саналыг 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 01/450 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Европын Холбооны Sociеux Plus байгууллагын төлөөлөгчтэй санал солилцох уулзалтыг 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав. Уулзалтаар Европын Холбооноос Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газраас Sociеux Plus байгууллагатай нийгмийн хамгааллын чиглэлээр зөвлөгөө мэдээлэл, туршлага солилцох, чадавхийг дээшлүүлэх богино хэмжээний сургалт, төсөл хөтөлбөрүүдийн талаар хамтран ажиллах тухай мэдээлэл солилцлоо.

Нийгмийн даатгалын ерөнхий газар Бүгд найрамдах Солонгос улсын Үндэсний тэтгэврийн алба хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр цахим уулзалт зохион байгуулав. Уулзалтын үеэр мэдээлэл технологийн чиглэлээр хамтран ажиллах, сургалтад мэргэжилтнүүдийг хамруулах, цаашид урт хугацаагаар хамтран ажиллах чиглэлээр харилцан ярилцаж санал солилцов.

### 1.1.5. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Хяналт, шалгалтын газар нь 2022 онд Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйгээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

#### Хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийж, тус хэлтсүүдийн 2017-2021 онуудын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн баримтууд, тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэг болон бусад анхан шатны баримтыг хамруулан шалгалаа.

#### *2022 онд хяналт шалгалтад хамрагдсан Нийгмийн даатгалын хэлтсүүд*

Тайлангийн хугацаа	№	Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн нэр	Илэрсэн төлбөр, зөрчлийн дүн <i>/сая төг/</i>	Шалгалтын хэлбэр
<b>2022 он</b>	1	Төв аймгийн НДХ	178.3	Төлөвлөгөөт хяналт, шалгалт
	2	Сүхбаатар аймгийн НДХ	24.1	
	3	Өвөрхангай аймгийн НДХ	0	
	4	Баянзүрх дүүргийн НДХ	1727.5	
		<b>Дүн</b>	<b>1929.9</b>	

Дээрх аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хийсэн шалгалтаар үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулсан, мөн хуурамч архивын лавлагаа гаргуулан хөнгөлөлттэй нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан 86 хүнтэй холбоотой 1834.0 сая төгрөгийн, байцаагчийн алдаанаас 103 хүнд илүү тооцож, олгосон 61.9 сая төгрөгийн, 50 хүнд дутуу олгосон 44.8 сая төгрөгийн, ажилгүйдлийн даатгалын сангаас 44 хүнд үндэслэлгүйгээр олгосон 29.6 сая төгрөгийн, 1 хүнд дутуу олгосон 1.1 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн, шалгалтын явцад 698.5 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож 81.9 хувийг барагдуулж ажиллав.

Хөдөлмөрийн хэвийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан 22600 тэтгэврийн тогтоолтыг, давхардсан тоогоор 388900 тэтгэврийн олголтыг шалгаж, 93100 идэвхитэй тэтгэвэр авагчийн, 6100 зогсоогдсон, нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг тоолж, Дархан-Уул, Сэлэнгэ, Увс, Архангай аймгуудын архивын газраас 136 тэтгэвэр авагчийн тушаалын үндэслэлийг шалгаж, 65 тэтгэвэр авагчийн тэтгэвэр анх тогтоолгосон баримтыг дахин бүрдүүлсний үндсэн дээр үргэлжлүүлэн олгохоор түр хугацаагаар түдгэлзүүлэн зогсоосон. Шалгалтаар илэрсэн нийт төлбөр, зөрчлийн 82,1 хувийг тэтгэврийн даатгалын сантай холбоотой төлбөр, зөрчил эзэлж байна.

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хийсэн шалгалтаар үндэслэлгүй баримтаар зардал гаргасан, түрээсийн орлогыг хуулийн дагуу төвлөрүүлээгүй нярав, нягтлан бодогч нарын хувийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн зэрэг 27.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн хуулийн дагуу залруулах арга хэмжээ авч улмаар шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авч, баталгаажуулах, өр авлагын барагдуулалт, санхүү бүртгэл болон хүний нөөцийн удирдлагын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

*Малчны болзлоор өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэдийн тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгаа.*

Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 3 аймаг, 1 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2018-2021 онуудад малчны болзлоор өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан нийт 4573 иргэний тэтгэврийн материалын үндэслэлийг шалгав. Шалгалтаар “Малчин даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар”-ын 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалтын дагуу нийгмийн даатгалын байцаагчид тус аймгуудын Засаг даргын Тамгын газрын архиваас гарсан А дансны лавлагааг үндсэн баримттай нь тулган шалгаагүй, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 1/1424 дугаар албан бичгээр хүргүүлсэн чиглэлд “Малчнаар ажилласан хугацааг зөвхөн нотлох баримтад тулгуурлан тогтоох” тухай заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрснийг арилгаж, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж хүргүүлээ.

*Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллалаа.*

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбарын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй холбоотой асуудлаар аймаг, орон нутагт 401, нийслэлд 503 зөрчлийн шинжтэй нийт 904 үйлдлийг шалгалаа. Шалгалтад хамрагдсан зөрчлийн 89.6 хувь буюу 810 хэргийг хялбаршуулсан журмаар, 0.3 хувь буюу 3 хэргийг зөрчлийн хэрэг нээж, 9.0 хувь 81 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 1.1 хувь буюу 10 хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна.

Нийт 894 аж ахуйн нэгж, байгууллагад 1155.8 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсний 586.5 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүд, 568.2 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс хариуцан шийдвэрлэж, 2022 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар нийт төлбөр, зөрчлийн 79.2 хувь 915.3 сая төгрөгийг барагдуулаад байна. Шалгалтад хамрагдсан 811 байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 203.0 сая төгрөгийн торгууль оногдуулан арга хэмжээ авч, 98.4 хувь буюу 200.0 сая төгрөгийг барагдуулав. Нийт торгуулийн 64.2 сая төгрөгийг орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсийн, 138.8 сая төгрөгийг холбогдох дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дансанд төвлөрүүллээ.

Нэгдсэн удирдамж, зөвлөмж боловсруулж салбарын хэмжээнд хяналт, шалгалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа.

Улс орны эдийн засаг болон цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан салбарын хэмжээнд гадагшаа чиглэсэн хяналт, шалгалтын ажлыг түр хугацаагаар хойшлуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, дотоодын хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах талаар 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 07/419 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүллээ. Түүнчлэн малчнаар өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан иргэдийн тэтгэврийн тогтоолт, олголт, баримтын бүрдэл, үндэслэлийг дотоодын хяналтаар шалгуулах тухай удирдамж боловсруулан шалгуулж, Хэнтий аймгийн нийгмийн даатгалын хэлтэст гүйцэтгэлийн хяналт хийж 21 тэтгэвэр авагчтай холбоотой 65.1 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 25.9 сая төгрөг буюу 39.8 хувийг барагдуулаад байна.

Гүйцэтгэлийн хяналт, шалгалтаар 461 тэтгэвэр авагчтай холбоотой 6,9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, улсын хэмжээнд нийт 1791 тэтгэвэр авагчтай холбоотой 12.8 тэрбум төгрөгийн зөрчлөөс 2022 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар 2.5 тэрбум төгрөгийг барагдуулаад байна.

Архивын лавлагааг хуурамчаар үйлдсэн нийт зөрчлийн 70 гаруй хувь нь Архивын ерөнхий газар болон Дархан-Уул, Увс, Архангай аймгуудын архивын тасгаас гаргаж, ирүүлсэн үндэслэлгүй лавлагаа болох нь тогтоогдлоо.

Мөн шалгалтын явцад үндэслэлгүй баритмаар шүүхийн шийдвэр гаргасан нэр бүхий 50 шүүгчийн 116 шийдвэрээр Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс нийт 2.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр тогтоолгон авсан мөн бусад аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс нэр бүхий 44 шүүгчийн 114 шийвэрээр 1.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр тогтоолгож, тэтгэврийн даатгалын санг хохироосон.

Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу даатгуулагчид тэтгэвэр тогтоож, олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа зөрчлийг арилгах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлыг хэсгийг Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 сарын сарын 11-ний өдрийн А/76 тоот тушаалаар байгуулсан.

Түүнчлэн уул, уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэгч 280 гаруй байгууллагын жагсаалт гаргаж, Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийг сурталчлах замаар нийт 46 байгууллагад хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

## 1.2. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах, шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үйл ажиллагааны талаар:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/73 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллан Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн тэтгэврийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их хуралд өргөн барив. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл дээр дахин ажиллаж Санхүү бүртгэлийн газар, Хяналт шалгалын газар, Тамгын газар, Дотоод аудит, мониторингийн газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, Мэдээллийн технологийн төвөөс холбогдох саналыг авч тусган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад орсон 2022 оноос эхлэн мөрдөх зохицуулалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой 1 журам, 4 заавар, 11 зөвлөмж чиглэлийг аймаг, дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 тоот тушаалаар “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”;
- 2022 оны А/17 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар”;
- 2022 оны А/99 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавих журмыг хэрэгжүүлэх заавар”;
- 2022 оны А/109 дүгээр тушаалаар “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай”;
- Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 20, 21 дүгээр тогтоол, 2022 оны 04 дүгээр тогтоолоор “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Тус газрын “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2022 оны 05/494, 05/1163, 05/1373, 05/13778 дугаар бүхий албан бичгүүд;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 01/923, 01/1112 дугаар албан бичиг зэрэг болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн хэрэгжилтийг зохион байгуулсан ажлын талаар:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөр 2022 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөлийн талаар аймаг, дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Уг зөвлөмжид 2022 онд өндөр насны тэтгэвэр тогтоох насыг эрэгтэй 60 нас 3 сар, эмэгтэй 56 нас 3 сараар баримтлах, мөн өөрийн



хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 настайдаа тогтоолгох даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 21 жил 3 сар байх зэрэг чиглэлийг тусгав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн “Журам батлах тухай” А/31 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг төслийг шинэчлэн боловсруулан батлуулж, уг тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, аймаг, дүүргийн хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулав.

Засгийн газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулав. Тухайлбал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар”-ыг батлуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээнд нийгмийн даатгалын сангаас болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, нэмэгдсэн тэтгэврийг 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгосноор уг арга хэмжээнд 469.2 мянган тэтгэвэр авагч хамрагдаж тэтгэврийн нэмэгдэлд 637.4 тэрбум төгрөг зарцуулав. Тэтгэвэр нэмэгдсэн арга хэмжээний дүнд дундаж тэтгэвэр 550.9 мянган төгрөгт хүрсэн болно.

Гадаад харилцааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Цаг уурын хүнд нөхцөлтэй гэж үзэх гадаад улсын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/32, А/246, А/81 тоот тушаалыг хэрэгжүүлэх, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тодорхойлж байгаа орон тооны бус зөвлөл нь зөвлөлийн дүрмийг баримтлах, нотлох баримтгүйгээр, мөн үндэслэлгүй баримт бичгээр даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тогтоохгүй байх зөвлөмж, чиглэл хүргүүлэв.

[Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажилласан талаар:](#)

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2022 оны хэмжээг тогтоох тухай 408 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд байгуулсан 2022 оны 2022/86, НД-71/22 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг зохион байгуулж, 2022 онд иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах хамтарсан чиглэлийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/109 дүгээр тушаалаар баталсан хүүхдээ асрах чөлөөтэй хугацаанд ажил олгогчоос хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгосон эх /эцэг/-ийг бүртгэх даатгуулагчийн төрлийн “68” код, цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон боловч ажил, хөдөлмөр эрхэлж байгаа цэргийн алба хаагчийг бүртгэх даатгуулагчийн төрлийн “69” кодыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Онцой байдлын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар,

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Төрийн тусгай хамгалалтын газар, Хил хамгаалах ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тус тус зөвлөмж хүргүүлж хамтран ажиллав.

Монгол Улсын Дээд шүүх “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ын 4.8.2 дахь заалтыг хүчингүй болгосонтой холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/165 тоот тушаалыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисстой хамтран магадлагч эмч, тасгийн дарга, тэтгэмжийн байцаагч нарт цахим уулзалт зохион байгуулав.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлсөн 31.8 мянган малчин, 2.6 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч, нийтдээ 34.4 мянган иргэний баталгаажилтын хуудсыг аймаг, дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн, даатгуулагчид олгох ажлыг зохион байгуулав. Эдгээр иргэдээс 19.6 мянган иргэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон, тэтгэвэрт нь 155.9 тэрбум төгрөг зарцуулаад байна. Уг хуулийн үйлчлэлийн хугацаа дууссантай холбогдуулан хуулийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийг барагдуулах зорилгоор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд ногдуулалт хийж, өглөгийг барагдуулах, илүү төлсөн шимтгэлийг буцаах зөвлөмж, чиглэлийг өгч ажилласнаар жилийн эцсийн байдлаар 3.7 сая төгрөгийн өглөгийг барагдуулав.

#### *Нийгмийн даатгалын хамралтын талаар:*

Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4.3 мянган ажил олгогч, 17.4 мянган даатгуулагчийг нийгмийн даатгалд шинээр хамруулах зорилтыг тусгаж, хяналт тавьж ажилласнаар 4.4 мянган аж ахуйн нэгж, байгууллага 134.1 мянган хүнийг нийгмийн даатгалд шинээр хамруулав.

Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 22.4 мянган хүнийг нийгмийн даатгалд шинээр хамруулахаар тусгасны дүнд 49.3 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулснаас 12.3 мянган малчинг сайн дурын даатгалд хамруулж шимтгэлийг нь төлүүлэх ажлыг зохион байгуулав.

#### *Нийгмийн даатгалын сангийн төсвийн төлөвлөлтийн талаар:*

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 10 дугаар тогтоолоор баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/03 дугаар тушаалаар баталсан аймаг, нийслэл, дүүргийн төсвийн сар, улирлын хуваарийг төв, орон нутгийн хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээг холбогдох судалгаанд үндэслэн тооцооноор

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар 637.3 тэрбум төгрөг батлуулсан. Үүнээс 310.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 300.0 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангийн харилцахын мөнгөн үлдэгдлээс, 27.2 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангийн 2022 оны зарлагын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн хүрээнд тооцоо, судалгааг хийснээр энэ хуулийн үйлчлэлд 648.0 мянган даатгуулагчид 150.2 тэрбум төгрөг олгохоор тооцон Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсөвт тусган Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн баталсан.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуулийг үндэслэн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн хуваарийг боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 02, 03 дугаар тогтоолоор тус тус батлуулан аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн хязгаарын саналыг тус тус боловсруулан төсвийн төсөл, төсөөллийг Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Үүнд: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550.0 мянган төгрөг болоход нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх нөлөөлөл, тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх, төсөвт байгууллагын цалинг 10-20 хувиар нэмэгдүүлэх, оршуулгын тэтгэмжийн хэмжээг 2.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоох зэрэг арга хэмжээнүүдийг тусгав.

Нийгмийн даатгалын байгууллагуудад улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын жилийн хязгаарын саналд 27.8 тэрбум төгрөгөөр тооцон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн хувилбар бүрээр тэтгэвэр нь нэмэгдэх хүний тоо, дундаж нэмэгдэл, нэмж шаардагдах хөрөнгийн тооцоог хийж, шаардагдах 156.2 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023 оны жилийн хязгаарын саналд тусгасан болно.

Тэтгэмжийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэх тооцоо, судалгааг боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр уг зөвлөлийн 4 дүгээр тогтоолоор оршуулгын тэтгэмжийг хэмжээг 2.0 сая төгрөгөөр, амьгүй донор болж эд, эс, эрхтнээ шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг 3,5 сая төгрөгөөр батлуулав. Энэ шийдвэрийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/98 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар”, “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын болон туслах үйл ажиллагааны орлогын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар”-ыг шинэчлэн батлуулж аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу “Төсвийн төсөл төсөөллийн санал ирүүлэх тухай” 2022 оны 1/1113 дугаар албан бичгийг аймаг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн холбогдох саналыг нь авч нэгтгэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарийг боловсруулж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн саналыг авч төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 6 удаа боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн шийдвэрлүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн төсөл, төсөөлөл боловсруулж ирүүлэх тухай болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 03 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэлтсийн дарга нарт хүргүүлэв.

[Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулсан ажлын талаар:](#)

Бүгд Найрамдах Унгар Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд тус улсаас тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 8 иргэний MN/HU 001 маягт, 2 иргэний оршин суух хаяг солигдсон тухай мэдээлэл, 18 иргэний Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг баталгаажуулах MN/HU205 маягт, 1 иргэний тэтгэвэр хүлээн авах дансны мэдээлэл, хариу ирэхгүй удааширч байгаа 26 иргэний сануулах маягтыг тус тус гарган Бүгд Найрамдах Унгар Улсын талд шуудангаар илгээв. Монгол Улсын хоёр иргэн Бүгд Найрамдах Унгар Улсаас өндөр насны тэтгэвэр шинээр тогтоолгов. Энэ хэлэлцээрийн дүнд нийт 34 иргэн Бүгд Найрамдах Унгар Улсаас сар бүр тэтгэвэр авч байна.

Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын “Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэхэд ашиглах маягтын загваруудыг 2 талын ажлын хэсгийн гишүүд боловсруулж, 2022 оны 3 дугаар сард 2 тал албан ёсоор баталснаар хэрэгжилтийг зохион байгуулж эхлэв.

Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хооронд тэтгэврийн салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг хэлэлцэх шинжээчдийн ажлын хэсгийн 12 дахь удаагийн Хэлэлцээнд оролцож, Хэлэлцээрийн төслийн эцсийн хувилбарыг тохиролцов.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн даатгалын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой зохион байгуулсан 2 талын ажлын хэсгийн цахим уулзалтад оролцож Хэлэлцээрийн төсөлд оруулахаар тохирсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж, талууд үндэсний хууль тогтоомжийн дагуу хэлэлцээрийн төслийг дотооддоо үргэлжлүүлэн хэлэлцэхээр тохиролцов. Хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой 2 талын ажлын хэсгийн уулзалтад тоон мэдээ, мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд цахим шуудангаар 2 удаа хүргүүлэв.

### **1.3. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Бүгд найрамдах Солонгос улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг нь 2022 онд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, бусад холбогдох хууль тогтоомжуудыг тус тус хэрэгжүүлэн дараах үйл ажиллагааг явуулав.

#### **1.3.1. БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдэд Монгол Улсын нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжуудыг сурталчлан таниулж, сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажлын хүрээнд**

БНСУ-ын Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэн, харьяатын газраас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар гаргасан статистик мэдээгээр БНСУ-д Монгол Улсын 50,153 иргэн оршин сууж байна. Энэ нь 2021 оны мөн үеийнхээс 13,203-аар өссөн үзүүлэлт юм.

Үүнээс хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн тоо 4,416, түр хугацааны визтэй иргэд 20,801, байнгын оршин суугч 730, окутан 6,350, солонгос иргэнтэй гэр бүл болсон 1,951, гэр бүлийн визтэй 3,438 иргэн байгаагаар тус тус бүртгэгдсэн байна.

#### *Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай сургалт, сурталчилгаа хийх, явуулын үйлчилгээ зохион байгуулах*

2022 онд тус тасаг “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор суугаа орны мөрдөж буй дүрэм, журамтай зохицуулан БНСУ-д ажиллаж, амьдарч буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн болон сайн дурын даатгалд хамруулах, иргэдэд нийгмийн даатгалын ашиг тусыг ойлгуулах, хуулийн өөрчлөлтүүдийг зөв мэдээлэх, шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор дараах сургалт, сурталчилгааны ажлууд болон явуулын үйлчилгээг зохион байгуулан амжилттай ажиллалаа. Үүнд:

- Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” фэйсбүүк хуудас болон <https://seoulcenter.mlsp.gov.mn> сайтуудад нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн талаар тогтмол мэдээ, мэдээлэл нийтэлж, иргэд, даатгуулагчдад сурталчлав.

- Нийгмийн даатгалын ерөнхий газраас иргэд даатгуулагчдад зориулан “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” сэдэвт цахим сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг сургалтад тус тасгийн мэргэжилтэн М.Лхагвасүрэн “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд болон БНСУ дахь Нийгмийн даатгалын үйлчилгээний тухай” танилцуулан иргэдийн сонирхсон асуултанд хариулсан.

- 2022 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Гуанжу хотноо болсон “Монгол наадам”-ын арга хэмжээнд оролцсон 50 орчим иргэдэд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай сурталчлан таниулж ажилласан.

- 2022 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Өмнөд Чолла мужийн Мугпу хотноо “Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээ”-г зохион байгуулсан бөгөөд тус хотод суугаа иргэд, даатгуулагч нарт нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлсэн.

- 2022 оны 10 дугаар сарын 8, 9-ний амралтын өдрүүдэд БНСУ-ын Умард Чолла мужийн Чонжү хотноо Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Консулын хэлтэс, Төрийн банк, Хаан банкттай хамтран “Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээ”-г үзүүлсэн бөгөөд давхардсан тоогоор 200 орчим иргэд ирсэн байна.

- Мөн оны 10 дугаар сарын 8, 9-ний амралтын өдрүүдэд Сөүл хотын Түндэмүн дүүргийн Рамада зочид буудлын уулзалтын танхимд “Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээ”-г үзүүлж давхардсан тоогоор 400 орчим монгол иргэд ирж нийгмийн даатгалын асуудлуудаар зөвлөгөө мэдээлэл авсан.

- Тус улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй гэрээт ажилчдад нийт 9 удаагийн “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн танилцуулга” сургалтыг амжилттай зохион байгуулсан.

*Иргэд, даатгуулагчид болон ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар ажлын байран дээр болон утас, цахим хэлбэрээр мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх*

Нийгмийн даатгалын талаар мэдээлэл авахыг хүссэн иргэд, даатгуулагч, ажил олгогчдод утсаар, цахимаар, биечлэн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 13,078, үүнээс 12,983 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 95 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

Үүнд: Даатгалд шинээр хамрагдах 483, даатгалын гэрээ сунгах 816, гэрчилгээ дахин авах 180, шимтгэлийн төлөлт шалгуулах 1,033, нэхэмжлэл, шимтгэл төлсөн баримт авах 742, буцаан олголтын тухай 70, БНСУ-ын ҮТА-д шимтгэл төлөх хүсэлтээ илэрхийлж, тодруулга авах тухай 438, нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэтгэвэр тэтгэмж болон бусад мэдээллийн талаар 722 иргэн, даатгуулагч, ажил олгогчид мэдээлэл, заавар, зөвлөгөө өгсөн байна.

*1.3.2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд*

*БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд бүртгүүлсэн байдал, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх*

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын дагуу Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулан ажиллаж байна.

Тус тасаг үүсгэн байгуулагдсан 2007 оны 3 дугаар сараас хойш БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулж, “Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн програм” /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/> буюу мэдээллийн санд бүртгэн нийт 23,667 /давхардсан тоогоор/ даатгуулагчийн бүртгэлийг хийсэн байна.


Тэтгэврийн даатгалд даатгуулсан, мэдээллийн санд бүртгэлтэй нийт 23,667 даатгуулагчийг шилжилт хөдөлгөөнөөр ангилбал одоо ажиллаж байгаа 2,198, холбоо барих боломжгүй 199, хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж, нутаг буцсан 21,270 даатгуулагч байгаагаар бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд мэдээллийн санд давхардсан тоогоор нийт 522 даатгуулагчийн шилжилт хөдөлгөөн болон мэдээлэлд өөрчлөлт хийсэн байна.

*Тэтгэврийн даатгалд даатгуулагчдын програм дахь шилжилт хөдөлгөөний мэдээллийг мэргэжилтэн тус бүрээр харуулбал:*

№	Мэргэжилтний нэр	Нийт даатгуулагчдын тоо	Ажиллаж буй даатгуулагчид	Нутаг буцсан	Харласан
1	Л.АЗЗАЯА	434	339	93	2
2	Ц.БЯМБАА	1061	506	553	2
3	О.ДАВААЖАВ	537	289	246	2
4	Л.ДОРЖСҮРЭН	469	245	221	3
5	Г.ДОЛГОРМАА	463	299	159	5
6	Ц.ЭРДЭНЭЦЭЦЭГ	321	297	22	2
7	М.ЛХАГВАСҮРЭН	1265	223	859	183
8	МОНГОЛ БУЦСАН	19117		19117	
	<b>БҮГД</b>	<b>23,667</b>	<b>2,198</b>	<b>21,270</b>	<b>199</b>

Нийт бүртгэлтэй даатгуулагчдын шилжилт хөдөлгөөнийг хувиар гаргавал, 9 хувь нь ажиллаж байгаа, 1 хувь нь холбоо барих боломжгүй болсон, 90 хувь нь хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж нутаг буцсан байдалтай байна.

*Даатгуулагчдын шилжилт хөдөлгөөнийг графикаар харуулбал:*



*БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй иргэдийг Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд хамруулах*

2019 оноос хойш “Коронавирус”-ын тархалтаас үүдэн БНСУ-ын тал гадаад улсаас хөдөлмөрийн гэрээт ажилтан авахгүй байсан бөгөөд 2021 оны 11 сараас эхлэн гэрээт ажилчдыг бага багаар татан авч нийт 2022 оны байдлаар 1,037 иргэн хөдөлмөрийн гэрээгээр ирсэн байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн нийт 375 иргэнийг шинээр хамруулан, гэрээ байгуулж, “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн програм” /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/> буюу мэдээллийн санд бүртгэв.

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын гэрээний хугацаа дуусаж, сунгалт хийлгэхээр хүсэлт гаргасан 468 даатгуулагчийн гэрээний хугацааг сунгаж, /<https://app.ndaatgal.mn:811/ndweb/> програмд бүртгэсэн.

*БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдэд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох*

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэд, даатгуулагчдад Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг нийтдээ 1,005 ширхэгийг бичиж, олгосон байна. Үүнд: шинээр олгосон 374, гэрээ сунгаж олгосон 468, ажил олгогч, даатгуулагчийн хүсэлтээр дахин олгосон 163 байна.

*Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд иргэдийг хамруулсан болон даатгуулагчдад гэрчилгээ бичиж олгосон байдлыг сар бүрээр харуулбал:*

Сар	Тэтгэврийн даатгалд шинээр хамрагдсан	Гэрчилгээ олгосон байдал		
		Шинээр	Сунгалт хийсэн	Дахин
1	23	22	51	16
2	48	32	36	8
3	18	18	34	6
4	37	45	58	13
5	59	59	38	8
6	33	34	45	11
7	14	14	28	14
8	20	29	28	15
9	53	55	27	10
10	22	21	22	14
11	13	13	43	33
12	35	32	58	15
<b>Нийт Бүгд</b>	<b>375</b>	<b>374</b>	<b>468</b>	<b>163</b>
			<b>1005</b>	

*1.3.3. БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох*

*Хөдөлмөрийн гэрээнээс бусад хэлбэрээр БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/110 дугаар тушаалаар “БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх журам” батлагдсан. Энэхүү журмыг хэрэгжүүлэн, програм хангамжийг шинээр нэвтрүүлж, 2015 оны 5 дугаар сараас БНСУ-д оршин сууж буй иргэдийг анх удаа нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулж эхэлсэн байна. Энэ хугацаанд нийтдээ 1,604 иргэнийг хамруулан гэрээ байгуулж, сайн дурын даатгалын хувийн хэргийг нээн ажилласан байна.

Тайлант хугацаанд нийт сайн дурын даатгалд хамрагдсан гэрээний хугацаа нь хүчинтэй байгаа 910 даатгуулагчийн хувийн хэргийг хариуцан сайн дурын даатгалын “<https://app.ndaatgal.mn:811/sdkorea/gereelist.aspx>” програмд хяналт тавин ажиллав. Шинээр 215 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулж, 2 сараас 1 жилийн хугацаатайгаар гэрээ байгуулан ажиллав.



*Сайн дурын даатгалд даатгуулсан иргэдэд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох*

БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс (Е-9, Е-8, Н-2-оос бусад төрлийн визтэй) өөр хэлбэрээр ажил хөдөлмөр эрхлэн Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд даатгуулсан иргэдийн хүсэлтээр тус тасаг тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан 302 гэрчилгээг олгожээ.

*Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулсан, гэрээнд хяналт тавин ажилласан болон гэрчилгээ олгосон байдлыг мэргэжилтэн бүрээр харуулбал:*

Д/д	Нэрс	САЙН ДУРЫН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧДЫН ТОО						Гэрчилгээ олгосон байдал
		2022 оны нийт даатгуулагчдын тоо				Нийт хувийн хэргийн тоо		
		Шинээр бүртгэсэн	Гэрээ сунгасан	Гэрээ цуцалсан, дууссан	2022 онд харуулсан гэрээний тоо	Хүчингүй хувийн хэргийн тоо	Нийт байцаагчид байгаа хувийн хэргийн тоо	
1	Л.АЗЗАЯА	46	84	18	148	126	274	61
2	Ц.БЯМБАА	13	90	4	107	101	208	19
3	О.ДАВААЖАВ	44	56	10	110	86	196	55
4	Г.ДОЛГОРМАА	14	103	5	122	128	250	22
5	Л.ДОРЖСҮРЭН	19	101	22	142	55	197	24
6	М.ЛЖАГВАСҮРЭН	44	108	10	162	80	242	64
7	Ц.ЭРДЭНЭЦЭЦЭГ	35	93	10	138	99	237	57
<b>НИЙТ</b>		<b>215</b>	<b>635</b>	<b>79</b>	<b>929</b>	<b>675</b>	<b>1604</b>	<b>302</b>

*1.3.4. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд*

Тус тасгийн 2022 оны нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 2,820,100,000.00 төгрөгөөр батлагдсан ба сар бүрийнх 235,008,333.33 төгрөг болно.

2022 оны тайлант хугацаанд нийгмийн даатгалын санд нийт 1,044,213,612.00 вон буюу 2,527,410,531.33 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 89.6 хувиар амжилттай биелүүлсэн.

Үүнд: Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 530,628,790 вон буюу 1,284,042,487.6 төгрөгийг, сайн дурын даатгалын шимтгэлийн орлого 513,584,822 вон буюу 1,243,368,043.73 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Тус тасаг нь 2007 оны 3 дугаар сараас 2022 оныг дуусталх 15 жил 9 сарын хугацаанд Монгол Улсын нийгмийн даатгалын санд БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр болон бусад хэлбэрээр хөдөлмөр эрхэлж буй иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нийт **19.8** тэрбум вон буюу **34.6** тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс тэтгэврийн даатгалын шимтгэлд 17.1 тэрбум вон, сайн дурын даатгалын шимтгэлд 2.6 тэрбум воны орлогыг тус тус төвлөрүүлсэн.

**Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэлтийг орлогын төлөвлөгөөтэй харьцуулсан байдал, сар бүрээр харуулбал:**

/2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр/


Сар	Жилийн орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэрийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого		Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гаригийн хаалтын ханш
			Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
1	2,820,100,000	235,008,333.33	38,760,000.00	92,636,400.00	41,161,666.00	98,376,381.74	79,921,666.00	191,012,781.74	81	2.39
2		235,008,333.33	43,164,500.00	102,731,510.00	39,741,453.00	94,584,658.14	82,905,953.00	197,316,168.14	84	2.38
3		235,008,333.33	50,581,000.00	118,359,540.00	41,339,628.00	96,734,729.52	91,920,628.00	215,094,269.52	92	2.34
4		235,008,333.33	48,750,000.00	119,437,500.00	38,617,802.00	94,613,614.90	87,367,802.00	214,051,114.90	91	2.45
5		235,008,333.33	44,501,590.00	108,583,879.60	45,553,977.00	111,151,703.88	90,055,567.00	219,735,583.48	94	2.44
6		235,008,333.33	43,939,000.00	109,408,110.00	40,628,423.00	101,164,773.27	84,567,423.00	210,572,883.27	90	2.49
7		235,008,333.33	42,096,000.00	101,872,320.00	42,141,974.00	101,983,577.08	84,237,974.00	203,855,897.08	87	2.42
8		235,008,333.33	44,330,000.00	107,721,900.00	45,099,242.00	109,591,158.06	89,429,242.00	217,313,058.06	92	2.43
9		235,008,333.33	44,171,700.00	103,361,778.00	40,846,462.00	95,580,721.08	85,018,162.00	198,942,499.08	85	2.34
10		235,008,333.33	45,140,000.00	104,273,400.00	47,372,186.00	109,429,749.66	92,512,186.00	213,703,149.66	91	2.31
11		235,008,333.33	40,255,000.00	97,014,550.00	44,726,632.00	107,791,183.12	84,981,632.00	204,805,733.12	87	2.41
12		235,008,333.33	44,940,000.00	118,641,600.00	46,299,277.00	122,230,091.28	91,239,277.00	240,871,691.28	102	2.64
		<b>2,820,100,000.0</b>	<b>530,628,790.00</b>	<b>1,284,042,487.60</b>	<b>513,528,722.00</b>	<b>1,243,232,341.73</b>	<b>1,044,157,512.00</b>	<b>2,527,274,829.33</b>	<b>89.6</b>	

**Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэлтийг мэргэжилтэн бүрээр харуулбал:**

/2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр/

Нэрс	Сарын орлогын төлөвлөгөө	2022 он						Биелэлтийн хувь
		Албан журмын даатгалын орлого		Сайн дурын даатгалын орлого		Нийт орлого		
		Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	
Л.Азаяа	402,871,428.00	99,286,000.00	240,718,320.00	93,302,353.00	226,158,569.25	192,588,353.00	466,876,889.25	116
Ц.Бямбаа	235,008,333.00	43,974,000.00	105,292,220.00	36,410,809.00	87,457,635.71	80,384,809.00	192,749,855.71	82
Б.Даваажав	402,871,428.00	56,810,700.00	137,593,138.00	50,047,587.00	121,276,581.99	106,858,287.00	258,869,719.99	64
Л.Доржсүрэн	470,016,666.00	75,340,000.00	182,491,000.00	66,616,088.00	161,922,213.08	141,956,088.00	344,413,213.08	73
Ц.Эрдэнэцэцэг	402,871,428.00	103,053,090.00	249,944,559.60	88,485,595.00	213,987,666.85	191,538,685.00	463,932,226.45	115
Г.Долгормаа	335,726,190.00	51,305,000.00	122,707,050.00	53,267,612.00	127,913,450.53	104,572,612.00	250,620,500.53	75
М.Лхагвасүрэн	570,734,523.00	101,260,000.00	246,352,200.00	125,342,678.00	304,387,344.32	226,602,678.00	550,739,544.32	96

*Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэлтийн гүйцэтгэлийг графикаар, сар бүрээр, төгрөгөөр харуулбал:*



1.3.5. Нийгмийн даатгалын мэдээллийн санд даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогыг бүртгэх

Тайлант хугацаанд даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлд төлсөн орлогыг БНСУ-ын харилцагч Шинхан, Хана, Үри, Гүгмин 4 банкнаас өдөр бүр интернет банкаар татан авч, <https://app.ndaatgal.mn:811/ndweb> програмд бүртгэж, хяналт тавин ажиллав.

Даатгуулагчдын сайн дурын даатгалын шимтгэлд төлсөн орлогыг харилцагч Гүгмин банкнаас өдөр бүр интернет банкаар татан авч, нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн “Харилцах 2022” програмд төгрөгт хөрвүүлэн шивж, хяналт тавин ажиллав. Мөн сайн дурын даатгалын шимтгэлийн орлогыг “Сайн дур даатгалын сан” эксел файлд бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Өргөдлийн дагуу даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогын дүнд залруулга хийх, мэдээллийн санд бүртгэх

Тайлант хугацаанд даатгуулагчид, ажил олгогчдын шимтгэл төлөх дансанд буруу шилжүүлэг хийсэн өргөдлийг хүлээн авч, журмын дагуу зохих баримтыг бүрдүүлэн, залруулгыг хийж, холбогдох програм, мэдээллийн санд мэдээллийг бүртгэн, хяналт тавьж ажиллав. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг данс андуурч шилжүүлснийг залруулах, илүү төлсөн шимтгэл болон данс андуурч даатгуулагчийн цалинг буруу шилжүүлснийг буцаан авах зэрэг нийт 23 өргөдлийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зохих баримтыг бүрдүүлэн “<https://app.ndaatgal.mn:811/ndweb>” програмд залруулгыг хийж бүртгэсэн.

- Сайн дурын даатгалд илүү төлсөн шимтгэлийг буцаан авах, шимтгэлийг данс андуурч шилжүүлэх, төлсөн шимтгэлийг шилжүүлэн тооцуулах зэрэг нийт 32 өргөдлийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зохих баримтыг бүрдүүлэн нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн “Харилцах 2022” програм болон “Сайн дур даатгалын сан” эксел файлд залруулгыг хийж гүйцэтгэв.

### *Төвлөрүүлсэн орлогыг нийгмийн даатгалын санд шилжүүлсэн байдал*

Тайлант хугацаанд тус тасгийн төвлөрүүлсэн шимтгэлийн орлогоос НДЕГ-ын Төрийн банкин дахь нийгмийн даатгалын сангийн дансанд нийт 2 тэрбум 559.1 сая, үүнээс тэтгэврийн даатгалын санд 2 тэрбум 373.03 сая, тэтгэмжийн даатгалын санд 93.07 сая, ҮОМШӨ-ний даатгалын санд 93.07 сая төгрөгийг тус тус шилжүүлэв.

### *Нийгмийн даатгалын санд шилжүүлсэн шимтгэлийн орлогын дүн /төгрөгөөр/ /2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр/*

Сар	Даатгалын сангийн төрөл			НДЕГ-ын Төрийн банкин дахь дансанд шилжүүлсэн нийт дүн
	Тэтгэврийн даатгал	Тэтгэмжийн даатгал	ҮОМШӨ-ний даатгал	
1	195,303,130.82	7,775,717.04	7,775,717.04	210,854,564.90
2	181,806,936.22	6,839,879.62	6,839,879.62	195,486,695.46
3	223,359,940.38	8,566,407.69	8,566,407.69	240,492,755.76
4	189,145,985.52	6,206,223.30	6,206,223.30	201,558,432.12
5	206,045,935.82	8,386,561.43	8,386,561.43	222,819,058.68
6	184,035,777.64	6,921,863.08	6,921,703.36	197,879,344.08
7	194,895,361.25	7,643,495.75	7,643,495.75	210,182,352.75
8	178,107,064.38	6,934,023.35	6,934,023.35	191,975,111.08
9	182,260,771.31	7,396,025.80	7,396,025.80	197,052,822.91
10	195,005,532.34	7,889,658.66	7,889,658.66	210,784,849.66
11	208,826,073.50	8,468,254.08	8,468,254.08	225,762,581.66
12	234,237,994.89	10,051,597.80	10,051,597.80	254,341,190.49
<b>Нийт дүн</b>	<b>2,373,030,504.07</b>	<b>93,079,707.60</b>	<b>93,079,547.88</b>	<b>2,559,189,759.55</b>

### *Даатгалын шимтгэлийг хугацаанд нь төлөөгүй даатгуулагчидтай холбогдож, шимтгэлийн авлага барагдуулах*

Даатгалын гэрээний хугацаа дуусаагүй боловч шимтгэл төлөхгүй байгаа даатгуулагчид цөөнгүй байгаа ба эдгээр даатгуулагчдыг шимтгэл төлүүлэх талаар дараах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- Иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдол, үр ашгийг сурталчлан таниулах, ойлгуулах, утас, факс, цахим гэх мэт бүхий л хэлбэрээр үнэн зөв мэдээллийг хүргэх, танилцуулга, брошюр тараах;

- Даатгалын шимтгэл төлөхгүй байгаа даатгуулагчдын ажил олгогчтой холбогдон, факсаар мэдээлэл, нэхэмжлэл илгээх, цалингаас суутгал хийн төлүүлж байх талаар мэдээлэл хүргэх;

- Даатгуулагч иргэдтэй өдрийн ажлын цагаар холбогдох боломжгүй байдаг тул орой уртасгасан цагаар ажиллаж, даатгалын шимтгэл төлөөгүй иргэдтэй утсаар шууд холбогдон шимтгэл төлөхийг шаардах;

- 3 сараас дээш даатгалын шимтгэлээ төлөөгүй байгаа даатгуулагчдын мэдээллийг тус төвийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасагтай хамтран “Гэрээт ажилчдын мэдээллийн нэгдсэн сан”-гаас сар бүр шалган, ажлын байраа сольсон эсэх,

ажил олгогч компаний нэр, утасны дугаар, хаягийг тодруулан холбогдож, авлагыг барагдуулах;

- Шимтгэл төлөөгүй даатгуулагчдын гар утас руу шимтгэл төлөхийг шаардсан мессеж, анхааруулга бичиж илгээх;

Тайлант хугацаанд шимтгэл төлөхгүй байгаа даатгуулагчид болон ажил олгогчдод факсаар давхардсан тоогоор 7,244 удаа шимтгэл төлөх нэхэмжлэл илгээсэн байна. Мөн утсаар болон цахим хэлбэрээр давхардсан тоогоор 9,019 даатгуулагч болон ажил олгогчтой холбогдож, шимтгэлийн төлөлт хийхийг шаардаж ярьсан. Мөн сар бүр шимтгэл төлөөгүй 730-750 даатгуулагчдын гар утас руу шимтгэл төлөхийг сануулсан мессеж бичиж илгээв.

1.3.6. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Е-8, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг буцаан олгуулах ажлын хүрээнд

*Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилт*

Монгол улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Бүгд найрамдах Солонгос улсын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд хамрагдан шимтгэл төлж байсан иргэдийн шимтгэлийн мөнгийг буцаан олгуулах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

2021 оны 12 дугаар сар болон 2022 онд Нийгмийн даатгалын ерөнхий газраас 167-оос 181 дүгээр ээлжийн нийт 15 удаагийн 74 иргэн буцаан олголт нэхэмжилснээс 167-оос 178 дугаар ээлжийн нийт 12 удаагийн 51 иргэний буцаан олголт бүрэн шийдэгдэж, 179,5 сая вон иргэдэд олгогдоод байна.

179, 180, 181 дүгээр ээлжийн 23 иргэний материалыг НДЕГ-аас хүлээн авч шалган, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвийн буцаан олголт хариуцсан ажилтанд хүргүүлсэн. Эдгээр иргэдийн буцаан олголт одоогоор шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

*Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу буцаан олголтоор авсан байдал*

№	Нэхэмжилсэн он	Ээлжийн дугаар	Иргэдийн тоо	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олгогдсон шимтгэлийн дүн /вон/
1	2021	167	6	6	14,331,060
2	2021	168	4	4	11,656,070
3	2021	169	5	4	18,683,050
4	2022	170	7	7	21,426,290
5	2022	171	3	2	12,630,020
6	2022	172	5	5	11,438,780
7	2022	173	5	5	29,542,850
8	2022	174	3	2	3,203,320
9	2022	175	7	7	16,704,700
10	2022	176	4	4	17,865,720
11	2022	177	3	3	16,681,020
12	2022	178	2	2	5,411,840
13	2022	179	6		
14	2022	180	8		
15	2022	181	6		
<b>Нийт</b>		<b>15</b>	<b>74</b>	<b>51</b>	<b>179,574,720</b>

*БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас тус улсад хөдөлмөрийн гэрээгээр (E-9, E-8, H-2 визээр) ажиллах хугацаандаа үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдэд шимтгэлийг буцаан олгосон байдал, тоон мэдээлэл*

Тус тасгаас БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвд хүсэлт тавин тус улсад хөдөлмөрийн гэрээгээр (E-9, E-8, H-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн Монгол Улсын иргэдэд “Гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх хууль”-ийн дагуу төлсөн шимтгэлийг буцаан олгосон байдлыг, статистик тоон мэдээллийг авсан болно. Үүнд:

*2019-2022 оны 8 дугаар сар хүртэл буцаан олголт авсан иргэдийн тоо болон мөнгөн дүн*

*/Хүний тоо, сая воноор/*

Огноо	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олголт авсан дүн
2022.08 сар	332	2,448
2021	591	3,666
2020	293	1,530
2019	518	2,428

*2019-2022 оны 8 дугаар сар хүртэл тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тоо*

*/Хүний тоогоор/*

Огноо	Нийт	Тахир дутуугийн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
2022.08 сар	49	2	47
2021	46	2	44
2020	45	2	43
2019	40	2	38

*2019-2022 оны хооронд MOU болон Инчоны нисэх онгоцны буудлаас буцаан олголт олгогдсон байдал*

*/Хүний тоо, сая воноор/*

Огноо	MOU		Инчоны нисэх онгоцны буудал	
	БО авсан иргэдийн тоо	БО авсан дүн	БО авсан иргэдийн тоо	БО авсан дүн
2022	54	214	303	2,447
2021	40	128	347	2,280
2020	73	204	148	888
2019	69	153	317	1,584

1.3.7. БНСУ-ын адил төст үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтарч ажиллах ажлын хүрээнд

Тайлант хугацаанд тус тасаг нь Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр, Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын алба хоорондын Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийн хүрээнд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын албаны Гадаад хамтын ажиллагааны төвтэй байнга мэдээлэл солилцон, харилцаа холбоотой ажиллаж, дараах арга хэмжээнүүдийг хамтран амжилттай зохион байгуулав. Үүнд:

- БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах, тус төвийн Нийгмийн даатгалын тасгийн дарга Л.Доржсүрэн болон холбогдох мэргэжилтнүүд Чонжу хотноо БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвийн албаны хүмүүстэй 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдөр уулзалт хийлээ. Уулзалтад БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвийн дарга Ким Сог Ён болон бусад холбогдох удирдлага, албан хаагчид оролцов. Тус уулзалтаар Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн Газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын НДЕГ, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын алба хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”, Үндэсний тэтгэврийн албаны Мэдээлэл технологийн төвтэй байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн хүрээнд хэрэгжиж буй ажлууд, цаашид хамтран хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлуудын талаар ярилцаж санал солилцсон.

- БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны хэлтсийн дарга Жу Юн Гү БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр ирж, тасгийн дарга Л.Доржсүрэнтэй хамтран ажиллах тухай санал солилцов.

- Тус тасгаас хамтран ажилладаг “Үри” банктай 2022 оны 8 дугаар сарын 8-ны өдөр уулзалт зохион байгуулсан бөгөөд уг уулзалтаар “НДЕГ болон Үри банктай хамтран ажиллах санамж бичиг”-ийг сунгах тухай харилцан санал солилцсон.

- БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Гадаад хамтын ажиллагааны төвийн хүсэлтийн дагуу нийт 4 удаа, Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамрагдан, тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ авсан 16 иргэний даатгалд хамрагдсан хугацааг жагсаалтаар гаргаж өгөв.

#### 1.4. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/25, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар нийгмийн даатгалын салбарын бүтэц, орон тоог шинэчлэн тогтоосон бөгөөд 2022 онд салбарын хэмжээнд 1,416 ажилтан, албан хаагч ажиллав.

##### *Нийгмийн даатгалын салбарын ажилтнуудын бүтэц*

№	Албан тушаалын ангилал	Тоо	Хувь
1	Удирдах албан тушаалтан	42	3.0
2	Гүйцэтгэх албан тушаалтан	1086	76.7
3	Үйлчилгээний	288	20.3
Нийт		1416	100

*Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо*

№	Төрийн албан тушаалын ангилал	Тоо
1	Жинхэнэ албан хаагч	1123
2	Төрийн үйлчилгээний албан хаагч	293
4	Үүнээс: Улсын байцаагч	872

*Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын боловсрол, мэргэжил*

Боловсрол				
№	Боловсролын зэрэг	Тоо	Мэргэжил	Тоо
1	Доктор	2	Санхүүч, Эдийн засагч, Нягтлан бодогч	1062
2	Магистр	162	Эрх зүйч	44
3	Бакалавр	1134	Бусад мэргэжил	1436
4	Бусад	118	-	-

*Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын нас, хүйсийн мэдээлэл*

№	Нас	Тоо	Хүйс	Тоо
1	30 хүртэлх	273	Эрэгтэй	412
2	31-40	504	Эмэгтэй	1004
3	41-50	411	-	-
4	51-60	228	-	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх дунд хугацааны 2022 оны төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 10 арга хэмжээтэй батлан биелэлтийг ханган ажиллалаа. Тайлант онд давхардсан тоогоор нийт 357 албан хаагчид 48,200 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.

### **1.3.1. БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮ, ТӨСВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх:**

*Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажлын талаар*

Нийгмийн даатгалын сангийн 3,300.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 3,445.9 тэрбум төгрөгийг хуримтлуулж, төлөвлөгөөг 104.4 хувиар биелүүлэв.

Нийгмийн даатгалын санд төвлөрсөн орлогыг сангаар тайлагнавал:

Нийгмийн даатгалын шимтгэлийн 3,300.8 тэрбум төгрөг хуримтлуулахаас 3,445.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулав. Үүнд:

-Тэтгэврийн даатгалын санд 2,857.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,969.4 тэрбум төгрөг,

-Тэтгэмжийн даатгалын санд 212.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 232.2 тэрбум төгрөг,

-ҮОМШӨ-ний даатгалын санд 185.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 198.4 тэрбум төгрөг,


-Ажилгүйдлийн даатгалын санд 45.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 45.9 тэрбум төгрөгийн шимтгэл хуримтлуулав.



*Нийгмийн даатгалын сангийн орлогыг өмнөх онтой харьцуулбал:*

*/тэрбум төгрөг/*

Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2021	2,398.7	2,732.0	113.9
2022	3,300.8	3,445.9	104.4



*Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох ажлын талаар*

Нийгмийн даатгалын сангаас 2022 онд 3,511.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохоос 3,376.4 тэрбум төгрөг олгов. Үүнд:

-Тэтгэврийн даатгалын сангаас 3,214.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 3,101.9 тэрбум төгрөг,

-Тэтгэмжийн даатгалын сангаас 187.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 163.9 тэрбум төгрөг,


-ҮОМШӨ-ний даатгалын сангаас 43.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 35.1 тэрбум төгрөг,

-Ажилгүйдлийн даатгалын сангаас 67.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 75.5 тэрбум төгрөг тус тус зарцуулав.

*Нийгмийн даатгалын сангийн зарлагыг өмнөх онтой харьцуулбал:*

*/тэрбум төгрөг/*

Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2021	2,567.1	2,565.5	99.9
2022	3,511.7	3,376.4	96.1



*Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийг өмнөх онтой харьцуулбал:*

*/тэрбум төгрөг, мянган хүн/*

№	Нийгмийн даатгалын сан	2021		2022	
		Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө
1.	Тэтгэврийн	455.5	2 281.8	474.3	3 101.9
2.	Тэтгэмжийн	260.9	169.4	220.9	163.9
3.	ҮОМШӨ-ний	5.7	30.7	6.8	35.1
4.	Ажилгүйдлийн	26.2	57.0	28.3	75.5
<b>Нийт</b>		<b>748.3</b>	<b>2 565.5</b>	<b>730.3</b>	<b>3 376.4</b>

*Нийгмийн даатгалын байгууллагуудад сангийн болон үйл ажиллагааны урсгал санхүүжилтийг шилжүүлэх ажлын талаар*

Сангийн санхүүжилт

- Тэтгэврийн даатгалын сан – 1,025.4 тэрбум төгрөг
- Тэтгэмжийн даатгалын сан – 12.7 тэрбум төгрөг
- ҮОМШӨ-ний даатгалын сан – 4.1 тэрбум төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сан – 34.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, хуулийн хугацаанд тэтгэвэр, тэтгэмж төлбөр зардал олгох боломжийг бүрдүүлэн ажиллалаа.

Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад 32.0 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны урсгал санхүүжилтийг хугацаанд нь олгосон. Үүнээс 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас төлөвлөгөөний дагуу нэхэмжлэн авсан.

*Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 15.0 хувиас хэтрүүлэхгүй байх ажлын талаар*

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах, ажил олгогч, даатгуулагчийг санхүүгийн эрсдлээс хамгаалах, нийгмийн баталгааг хангах зорилгоор аймаг /Нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /Газар/-д үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцон ажиллалаа.

Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотой аж ахуй нэгж байгууллагууд санхүүгийн хүндрэлд орсон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор өгсөн чиглэлийн дагуу шимтгэлийн хуримтлагдсан авлага үүсгэсэн ажил олгогчийн арилжааны банк дахь харилцах дансны зарлагын гүйлгээг хаах, шүүхэд шилжүүлэх арга хэмжээг хойшлуулсан байсан бөгөөд 2022 оны 10 дугаар сараас эхлэн ЭМНДЕГ-ын даргын 2017 оны А/108 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлж, шимтгэлийн авлагыг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллахыг аймаг, дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтэст даалган, хэрэгжилтийг ханган ажилласнаар дараах үр дүнд хүрсэн байна.

- Нийгмийн даатгалын шимтгэлийн 210.9 тэрбум төгрөгийн авлага барагдуулахаар цахимаар болон биечилсэн байдлаар 14,028 ажил олгогчтой уулзалт зохион байгуулж хамтран ажилласны үр дүнд 13,428 ажил олгогчийн 19.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн 36.0 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 990 ажил олгогчид албан шаардлага хүргүүлж, 9.8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн 47.0 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 1,302 ажил олгогчийн банк дах харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 1.2 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн 161.5 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 1,370 ажил олгогчтой шимтгэлийн авлага барагдуулах гэрээ байгуулж, 30.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн 3.0 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 118 ажил олгогчийг шүүхэд шилжүүлж, 1.1 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн 23.5 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн 569 ажил олгогчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, 1.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан.

Авлага барагдуулах арга хэмжээг дээрх журмын дагуу шат дараалан авч байгаа тул авлагын мөнгөн дүн, ажил олгогчийн тоо нь давхардсан дүнгээр илэрхийлэгдсэн болно.

Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын ажил олгогч, даатгуулагчаас авах шимтгэлийн авлагыг бууруулахад дэмжлэг үзүүлж, дараах ажлуудыг зохион байгуулан, хэрэгжилтийг тооцон ажиллалаа. Үүнд:

- Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах бодлогын хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн аж ахуй нэгж, байгууллагуудтай “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг тогтоосон хугацаанд барагдуулахаар тохиролцож байгуулсан гэрээ” байгуулан, төлөлтийн хуваарь баталж, гэрээний үүргийн хэрэгжилтийг үндэслэн даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгох ажлыг зохион байгуулав.

- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-нд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн эрүүл

мэндийн байгууллагын жагсаалтыг сар бүр хүргүүлснээр тус газартай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын шимтгэлийн авлага оны эхнээс 18.3 хувиар буурсан.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 01/2185 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 31.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн өртэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 48 хуулийн этгээдийн жагсаалтыг хүргүүлж, төлбөрийг бүрэн барагдуулах, цаашид шимтгэлийн өр нэмж үүсгэхгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах хүсэлт хүргүүлсэн бөгөөд тус газраас дээрх 48 хуулийн этгээдэд 2022 онд багтаан шимтгэлийн авлагыг бүрэн барагдуулах чиглэл, даалгавар өгсөн байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/91 дүгээр тушаалаар баталсан “Монголбанкны зээлийн мэдээллийн санд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллийг хүргүүлэхэд баримтлах журам”-ын хүрээнд 17,658 ажил олгогчийн шимтгэлийн авлагын талаарх мэдээллийг хүргүүлэв.

Дээрх авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнд оны эхний нийгмийн даатгалын шимтгэлийн 297.1 тэрбум төгрөгийн авлагаас 63.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлага барагдуулсан боловч урсгал авлага нэмэгдэж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар авлага 383.6 тэрбум төгрөг болсон.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын орлогод эзлэх хувь нь 14.95 байгаа нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан дүнд багтаж байна.

#### Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын талаар

Нийгмийн даатгалын сангийн санхүүжилтээр зохион байгуулагдах нийт 3,924.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 худалдан авалт, улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 300 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авалтын төлөвлөгөөг батлан, ажлыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгуулж, шалгарууллаа. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 2 худалдан авалт:

- XI.2.3.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын тоног төхөөрөмж худалдан авах 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын ажлыг 2022 оны 02 дугаар сарын 22-оос 03 дугаар сарын 02-ны хооронд зохион байгуулж, хөрөнгүүдийг хүлээн авч, гэрээний дагуу 44.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, барааг бүртгэлд тусгалаа,

- XI.2.2.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын байрны их засварын 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн ажлыг 2022 оны 02 дугаар сарын 25-аас 03 дугаар сарын 28-ны хооронд амжилттай зохион байгуулсан боловч “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар төсөв хасагдсан.

2. Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр батлагдсан 9 худалдан авалт:

- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах сервер лицензийн худалдан авалтыг 2022 оны 03 дугаар сарын 17-оос 04 дүгээр сарын 18-ны хооронд зохион байгуулж, шалгарсан Ай Ти Зон ХХК-тай “Худалдан авалтын гэрээ”-г байгуулан гэрээний дүн болох 1,014.2 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа.

- Ажлын компьютер, түүний дагалдах тоног төхөөрөмжийн худалдан авалтыг 2022 оны 04 дүгээр сарын 08-аас 05 дугаар сарын 09-ний хооронд зохион байгуулж, шалгарсан Ай Ти Зон ХХК-тай “Худалдан авалтын гэрээ”-г байгуулан гэрээний дүн болох 1,185.1 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэгчийг 2022 оны 06 дугаар сарын 15-22-ны хооронд сонгон шалгаруулж, 39.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн Шүтээн-Уул ХХК-тай ажлын гэрээ байгууллаа.

- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай тэтгэврийн хувийн хэрэг хэвлэн нийлүүлэгчийг 2022 оны 06 дугаар сарын 24-өөс 07 дугаар сарын 01-ний хооронд сонгон шалгаруулж 20.5 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн Соёмбопринтинг ХХК-тай гэрээ байгуулж тэтгэврийн хувийн хэргийг хэвлүүллээ.

- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай зөөврийн компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж худалдан авалтыг /Зөөврийн компьютер-1, Хэвлэх, хувилах төхөөрөмж-2, Програм хангамж-3/ 3 багц болгон 2022 оны 08 дугаар сарын 23-аас 09 дүгээр сарын 23-ны хооронд зохион байгуулж, шалгарсан Саммит компьютер технологи ХХК, Бодь-Электроникс ХХК, Ай Ти Зон ХХК-тай “Худалдан авалтын гэрээ”-г байгуулан гэрээний дүн болох 933.9 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа.

- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай ажлын компьютер, принтер худалдан авалтыг 2022 оны 10 дугаар сарын 20-оос 11 дүгээр сарын 21-ний хооронд зохион байгуулж, шалгарсан Ай Ти Зон ХХК-тай “Худалдан авалтын гэрээ”-г байгуулан гэрээний дүн болох 157.8 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгалаа.

- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай 47.1 сая төгрөгийн анхан шатны маягтыг шууд гэрээ байгуулан худалдан авлаа.

Дээрх худалдан авалтуудын сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсанаар нийт 3,974.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

[Нийгмийн даатгалын байгууллагуудтай Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн орлого санд төвлөрүүлэхэд хяналт тавих ажлын талаар](#)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн түрээсийн талаарх зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварын дагуу төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын байр, талбайг ашиглаж байгаа улсын төсөвт үйлдвэрийн 4 газар, 2 аж ахуйн нэгж, байгууллага, арилжааны 7 банк нийт 13 хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг сунгаж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан нийт 12 иргэн, хуулийн этгээдээс 93.0 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэв.

Түрээсийн орлогын тооцоонд сар бүр хяналт тавьж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 40% болох 37.0 сая төгрөгийг төвлөрүүлж ажиллалаа.

[Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах ажлын талаар](#)

Капитал банкны Эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн өр, төлбөрөөс тооцон авсан хөрөнгийг худалдан борлуулах нээлттэй дуудлага худалдааг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “Журам батлах тухай” 18 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 268 дугаар “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн зохион байгууллаа.

2022 онд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг нийт 8 удаа зохион байгуулж, 5.9 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 19 хөрөнгийг 6.0 тэрбум төгрөгөөр зарж, орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн ажиллалаа.

---oOo---

